

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Төрийн байгууллагын хүний нөөцийн тогтолцоо нь төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэхэд чиглэгдэж байгаа ч хууль, тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна.

АУДИТЫН КОД:УВА-2024/19-19-ШТА-ГА

Улаангом хот
2024 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор М.Батсуурь
Утас: 7045-3317, цахим хаяг: batsuurim@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Цахим хаяг: batamgalanm@audit.gov.mn
Ахлах аудитор Т.Намжил
Цахим хаяг: namjilt@audit.gov.mn
Аудитор Т.Амармэнд
Цахим хаяг: Amarmendt@audit.gov.mn
Аудитор Б.Нямбуу
Цахим хаяг: Nyambuub@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. www.audit.mn

АГУУЛГА

Агуулга	1-3
Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгтэн мэдээллийн жагсаалт	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	6-7
Ерөнхий мэдээлэл	8-9
Бүлэг 1 Төрийн байгууллагын хүний нөөцийн тогтолцоо нь төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэхэд чиглэгдэж байгаа ч хууль, тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна.	10
1.1 Төрийн байгууллагуудын хүний нөөцийн асуудлыг зохицуулж буй хууль тогтоомж, баримталж буй бодлогын зорилт арга хэмжээ нь нэгдмэл, харилцан уялдаатай, бүх талын оролцоог хангаж чадаж байна.	10
1.1.1 Төрийн байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц нь Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцэж байна.	10-12
1.1.2 Батлагдсан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг Боловсрол, Эрүүл мэнд, Соёлын салбарт бүрэн мөрдөхгүй байна.	12-13
1.1.2.1 Орон нутгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөрийг боловсруулж, баталгаажуулан хэрэгжүүлэх чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.	13
1.1.2.2 Аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүргээ аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлж байна.	13
1.1.2.3 Сумд нь аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилт, ажиллах нөхцөлийн чиг үүргийг сумын дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан байна.	14
1.1.3 Урт, дунд хугацааны бодлогын зорилтыг хэрэгжүүлэх олон талын уялдаа холбоо хангагдаж, биелэлтэд ахиц, дэвшил гарч байна.	14-15
1.1.4 Төрийн албаны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-үнэлгээ хийж, үр нөлөөг тооцож байна.	15-16
1.2 Төрийн байгууллагын хүний нөөцийн тогтолцоо нь төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэхэд чиглэгдэж байгаа ч Төрийн байгууллагуудын төсвийн хүрэлцээгүй байдал, албан тушаалын тодорхойлолт батлагдахгүй байгаа нь нөөцийн хуваарилалтад нөлөөлж байна.	16
1.2.1 Төрийн байгууллагуудад хүний нөөцийн хүрэлцээ харилцан адилгүй байна.	16-17
1.2.2 Төрийн байгууллагын үйлчилгээ нь иргэдэд ил тод нээлттэй байна.	17-18
1.2.3 Төрийн байгууллагуудын төсвийн хүрэлцээгүй байдал, албан тушаалын тодорхойлолт батлагдаж ирээгүй зэрэг нь нөөцийн хуваарилалтад нөлөөлж байна.	19-20
1.3 Төрийн байгууллагын хүний нөөцийн удирдлагын үр дүн хангалтгүй байна.	20
1.3.1 Ерөнхий боловсролын 27 сургуулиас бусад төрийн байгууллагуудад эрх бүхий байгууллагаас чиг үүргийн шинжилгээ хийж, албан тушаалын давхардал, хийдлийг арилгах арга хэмжээ аваагүй байна.	20-21
1.3.1.1 Төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийх эрх зүйн орчин бүрдсэн байна.	21
1.3.1.2 Төрийн байгууллагын чиг үүрэгт аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсээс шинжилгээ хийсэн байна.	21
1.3.1.3 Төрийн байгууллагын чиг үүрэгт хийсэн шинжилгээний үр дүнг үндэслэн арга хэмжээ авч байна.	22
1.3.1.4 Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийн боловсруулалт, баталгаажуулалт, гүйцэтгэлд дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.	22
1.3.1.5 Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсантай холбогдуулан албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт	22

	оруулах шаардлагатай байна.	
1.3.1.6	Төрийн байгууллагууд албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагад нийцсэн "албан тушаалын тодорхойлолт" боловсруулж, батлуулж чадахгүй байна.	23-24
1.3.2	Төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгаагаар хангах хөтөлбөр төсөл, үйл ажиллагаа, урамшуулах систем нь төсөв хүрэлцээгүйгээс шалтгаалан бүрэн хэрэгжүүлж чадахгүй байна.	24-25
1.3.2.1	Цалингийн шатлалыг Эрүүл мэндийн газраас бусад байгууллага, зэрэг дэвийн нэмэгдлийг төсөвт байгууллагууд үндэслэлтэй олгож байна.	25
1.3.2.2	Төрийн жинхэнэ албан хаагчид цалин, цол, зэрэг дэвийн нэмэгдлийг давхардуулан олгоогүй байна.	26
1.3.2.3	Төсөвт байгууллагууд орон нутгийн нэмэгдлийг 20-80 хувиар, бусад нэмэгдлийг хууль, тогтоомжийн хүрээнд олгож байна.	25-26
1.3.2.4	Төрийн байгууллагууд төрийн албан хаагчийг төсвөөс бус санхүүжүүлэн ажиллуулсан асуудал байхгүй байна.	26
1.3.2.5	Төрийн албан хаагчид нөхөх төлбөрийг төсөв санхүүжилтийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан холбогдох хууль, журмын дагуу олгож чадахгүй байна.	26-27
1.3.2.6	Төрийн албаны зардлыг бууруулах талаар төрөөс авах арга хэмжээний хүрээнд төрийн албан хаагчдад олгох цалин хөлс нэмэгдүүлэхийг болон нөхөх төлбөр, тусламжийг түр зогсоож байсан байна.	27
1.3.3	Төрийн байгууллагуудад гарсан сул орон тоог хууль болон холбогдох журмын дагуу олон нийтэд ил тод мэдээлж байгаа ч зарим байгууллага нөөцөд бүртгэгдсэн болон нээлтэй сонгон шалгаруулалтаар сонгогдсон албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан иргэдээс нөхөн томилоогүй байна.	27
1.3.3.1	Сул орон тоог олон нийтэд нээлттэй зарлан мэдээлж байна.	27-28
1.3.3.2	Зарим байгууллагууд сул орон тооны нөөцөд бүртгэгдсэн, нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгогдсон болон албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан иргэдийг нөхөн томилоогүй байна.	38-32
1.3.3.3	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар нь Төрийн үйлчилгээний ангилал зэрэглэлээр батлагдсан орон тоог төрийн жинхэнэ албаны ангилалд хамааруулан томилон ажиллуулсан байна.	33-34
1.3.3.4	Төрийн албаны тухай хуульд заасан стандартыг батлан мөрдүүлж байна.	34
1.3.3.5	Мерит зарчмын дагуу шатлан дэвших шаардлага, шалгуур нь байгууллагын түвшинд тодорхойгүй байна.	34
1.3.3.6	Шатлан дэвших тогтолцоо хэрэгжиж байна.	34
1.3.3.7	Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан шийтгэлтэй байх хугацаанд нь иргэнийг шатлан дэвшүүлсэн асуудал гараагүй байна.	35
1.3.4	Төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, төрд хохирол учруулсан байна.	35
1.3.4.1	Төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж хууль бусаар томилогдож, чөлөөлөгдсөн зөрчил байна.	35-36
1.3.4.2	Төрийн албан хаагчийн эрх зөрчигдсөн маргаан нь хууль, журмын дагуу шийдвэрлэгдэж байна.	36-37
1.3.4.3	Хууль бус шийдвэрээс шалтгаалан төрд учруулсан хохирлын хэмжээг тогтоож байна.	37
1.3.4.4	Төрд учруулсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх асуудал хууль хяналтын байгууллагаар дамжиж удаашрах, зарим хууль тогтоомжийн уялдаагүй байдлаас шалтгаалан хангагдахгүй байх асуудал үүсэж байна.	37-40
1.3.5	Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийн санг бүрэн	40

	бүрдүүлж, үр дүнтэй ашиглаж байна.	
1.3.5.1	Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн мэдээлэл үнэн зөв байна.	40-41
1.3.5.2	Төрийн албаны нөөцөд албан хаагчдыг бүртгэсэн байна.	41
1.3.5.3	Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлд хяналт хийгдэж байгаа ч төсвийн байгууллагуудын ажилтны хувийн хэргийн бүрдэл хангалтгүй байна.	41-42
Бүлэг2	Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож байна.	43
2.1	Иргэндээ үйлчилдэг мэргэшсэн, чадварлаг ил тод төрийн алба бүрдэж байгаа боловч төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай хүний нөөц дутагдалтай байна.	43
2.1.1	Төрийн албан хаагчдыг орон зайнаас үл хамааруулан сургаж байна.	43
2.1.1.1	Төрийн албаны сургалтын хөтөлбөр нь ил тод, нээлттэй байна.	43
2.1.1.2	Төрийн албан хаагчийн сургалтад шаардлагатай санхүүжилт хүрэлцээгүй байна.	43
2.1.1.3	Суралцах шаардлагатай төрийн албан хаагчийг сургалтад хамруулж байна.	44
2.1.2	Газар зүйн байршлаас үл хамааран мэдлэг чадвартай албан хаагчийг сэлгэн, шилжүүлэн ажиллуулж байна.	44-45
2.1.3	Төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай хүний нөөц дутагдалтай, бэлтгэх ажил хангалтгүй байна.	45-47
2.1.4	Төрийн албанд жендерийн тэнцвэртэй байдлыг хангаж байна.	47
2.1.4.1	Төрийн албан дахь жендерийн эрх тэгш байдлын баталгаа хангагдсан байна.	47-48
2.1.4.2	Төрийн албанд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах эрх зүйн орчин бүрдсэн ч хэрэгжилт хангалтгүй байна.	58-51
2.2	Иргэд төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран авах нөхцөл боломж бүрдсэн байна.	51
2.2.1	Цахим технологи ашиглан иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх тогтолцоог боловсронгуй болгож, шат дамжлагыг цөөлөн, хүнд суртлыг арилгасан байна.	51-52
2.2.2	Орон нутагт төрийн үйлчилгээ жигд, хүртээмжтэй хүрч байна.	52
2.3	Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдалд хийсэн санал асуулгын дүнгээс үзэхэд иргэд сэтгэл ханамжтай байна.	52
2.3.1	Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа уялдаа холбоотой ажиллаж байна.	53
2.3.2	Төрийн үйлчилгээний ил тод нээлттэй байдалд холбогдох байгууллагууд судалгаа хийж, хяналтын үр нөлөөтэй тогтолцоо бүрдсэн байна.	53-54
2.3.3	Орон нутагт төрийн албаны авлигын индексийг тогтоохгүй байна.	54
	Дүгнэлт	55
	Холбогдох байгууллагын санал	56-60
	Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар	61
	Зөвлөмж	62

Товчилсон үгийн тайлбар

УВА	Увс аймаг
ШТА	Шууд тайлагнах аудит
ГА	Гүйцэтгэлийн аудит
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ББЭХС	Баруун бүсийн эрчим хүчний систем
ХК	Хувьцаат компани
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
УИХ	Улсын их хурал
МУ	Монгол Улс
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ҮАГ	Үндэсний аудитын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ТЗ	Төрийн захиргаа
ТҮЭМ	Төрийн үйлчилгээ эрүүл мэнд
ХЭГ	Хэрэг эрхлэх газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
ШШ	Шүүхийн шийдвэр
ТЗУХ	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЦХИХХЯ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам

Хүснэгтэн мэдээллийн жагсаалт

Дугаар	Нэр	Хуудасны дугаар
1	Түүвэрт хамрагдсан байгууллагын жагсаалт	6
2	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Засаглалын талаар 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа	7
3	Увс аймгийн 2013-2023 оны төрийн албан хаагчийн тоо	8
4	Төрийн байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын	9
5	“Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т хүний нөөцийн бодлогын талаар	9-10
6	Аймгийн сургуулийн орон тооны жишиг нормативаар сурагчийн тоо	11
7	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	12
8	Боловсролын баримт бичгийн талаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн жагсаалт	14
9	Төрийн албаны зөвлөлд уламжилсан зөрчлийн судалгаа	14
10	Төрийн албаны зөвлөлд уламжилсан зөрчлийн судалгаа	17
11	Төрийн байгууллага, төрийн албан хаагчийн тоон мэдээ	
12	Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн бүртгэл	20-21
13	Аймгийн бодлогын баримт бичигт мэдээллийн технологийн чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээ	22
14	Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт	24
15	Төрийн байгууллагад ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо	25
16	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр төлсөн судалгаа	27
17	2023 оны байдлаар 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид эзлэх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувь	28-29
18	Мэдээллийн ил тод байдал	30

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 8 дугаар тогтоолд үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны 162 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Увс аймаг дахь Төрийн аудитын газар хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтын хүрээнд дараах дэд асуудлуудад аудитыг чиглүүлэн хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдсэн эсэх;
- Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож байгаа эсэх;

Аудитын хамарсан хүрээ:

“Төрийн албан хаагч гэж төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг хэлнэ” гэж заасан тодорхойлолтод хамаарах төрийн захиргааны, төрийн тусгай, улс төрийн, төрийн үйлчилгээний албан тушаалтнуудыг ажиллуулж байгаа төрийн байгууллагуудын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийг Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулж, батлуулж, мөрдөж байгаа байдлыг орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа улс, орон нутгийн төсвийн байгууллагууд, Увс аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлийн 2013-2023 оны үйл ажиллагааг хамруулсан.

Аудитын хөтөлбөрт тусгагдсан цаглаварт хугацаанд цаг хугацаа, хүний нөөцөөс шалтгаалан түүврийн арга ашигласан бөгөөд 7 сумын 34 байгууллага, аймгийн төвийн 17 байгууллага, нийт 51 байгууллагыг түүвэрт хамруулсан. Үүнд:

Хүснэгт 1.

Д/д	Байгууллагын нэр	Ангилал	Хамрагдсан байгууллагын тоо
1	Аймгийн Боловсролын газар	Улсын төсөв	1
2	Насан туршийн суралцахуйн төв	Улсын төсөв	1
3	Ерөнхий боловсролын 2-р сургууль	Улсын төсөв	1
4	Улаангом сумын 7-р цэцэрлэг	Улсын төсөв	1
5	Улаангом сумын 9-р цэцэрлэг	Улсын төсөв	1
6	Улаангом сумын 11-р цэцэрлэг	Улсын төсөв	1
7	Улаангом сумын 12-р цэцэрлэг	Улсын төсөв	1
8	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	Улсын төсөв	1
9	Эрүүл мэндийн газар	Улсын төсөв	1
10	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар	Улсын төсөв	1

11	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	Орон нутгийн төсөв	1
12	Худалдан авах ажиллагааны газар	Орон нутгийн төсөв	1
13	Улаангом сумын ЗДТГ	Орон нутгийн төсөв	1
14	Аймгийн ЗДТГ	Орон нутгийн төсөв	1
15	Аймгийн ИТХ	Орон нутгийн төсөв	1
16	ББЭХС	ТӨХК	1
17	Чандмань Увс ХХК	ОНӨХХК	1
18	Сагил сум	Улсын төвийн 4, орон нутгийн төсвийн 1	5
19	Түргэн сум	Улсын төвийн 4, орон нутгийн төсвийн 1	5
20	Наранбулаг сум	Улсын төвийн 4, орон нутгийн төсвийн 2	6
21	Өлгий сум	Улсын төвийн 4, орон нутгийн төсвийн 2	6
22	Өмнөговь сум	Улсын төвийн 4, орон нутгийн төсвийн 2	6
23	Завхан сум	Улсын төвийн 4, орон нутгийн төсвийн 2	6
	Нийт		51

Аудитын арга зүй:

Аудитад Гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг баримтлан аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримт цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх, судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг арга зүйг ашигласан.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа

Гүйцэтгэлийн аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан хэрэгжүүлэн, ахлах аудитор Т.Намжил, аудитор Т.Амармэнд, Б.Нямбуу нар 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Аудитын дүн

Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөөнд хийсэн аудитаар 7 зөвлөмж өгч, Үндэсний аудитын газарт 1 санал хүргүүлсэн болно.

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас өмнөх онуудад гүйцэтгэсэн аудитаар илрүүлсэн төрд учруулсан хохиролтой холбоотой зөрчлийг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Төрийн албаны Увс аймаг дахь салбар зөвлөлд шилжүүлсэн болон Төрийн албаны Увс аймаг дахь салбар зөвлөлөөс илрүүлэн хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн зөрчлүүдийг аудитын тайланд давхардуулан тусгаагүй болно.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Төрийн албаны тухай хууль нь анх 1994 оны 12 дугаар сарын 30-ны өдөр батлагдаж, 1995 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн байна. Дээрх хуулийг 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр, 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр шинэчлэн найруулж, хамгийн сүүлд 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр хуульд нэмэлт оруулсан байна.

УИХ-ын 1996 оны “Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлтийн талаар баримтлах бодлогын тухай” 38 дугаар тогтоолыг баталсан байна. Уг тогтоолоор Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг зөвшөөрч, 1996 оноос эхлэн хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгажээ.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталж, Засаглалын талаар Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болохоор зорилгоо тодорхойлжээ. Зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- **Зорилт 5.1.** Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана.
- **Зорилт 5.2.** Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна.
- **Зорилт 5.3.** Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.
- **Зорилт 5.4.** Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ.
- **Зорилт 5.5.** Иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоог бүрдүүлнэ.
- **Зорилт 5.6.** Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тогтоолын 2 дугаар хавсралтаар баталж, бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн дараагийн үе шатны хүрэх үр дүнтэй нийцүүлэн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг тодорхойлж УИХ-аар батлуулахыг Засгийн газарт үүрэг болгон, хэрэгжилтийн явцад 5 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, УИХ-д танилцуулахаар тусгасан байна.

Хүснэгт 1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Засаглалын талаар. 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Хүснэгт 2.

№	Засаглал	Зорилтууд	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа
1	Ухаалаг засаглал	5.1.	20
2	Ухаалаг бүтэц	5.2.	22
3	Цахим монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем)	5.3.	23
4	Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба	5.4.	17
5	Хүний эрхийг дээдэлсэн нийгэм	5.5.	9
6	Авлигагүй засаглал	5.6.	8

Эх сурвалж: “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт

Төрийн албаны төв байгууллагын гаргасан төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлээр 2023 онд 226496 албан хаагч бүртгэгдсэнээс Увс аймагт 5741 төрийн албан хаагч байна. Үүнд:

- Төрийн улс төрийн албан тушаалд 157 албан хаагч ажиллаж байгаа нь нийт төрийн албан хаагчийн 2.7 хувь;
- Төрийн захиргааны албан тушаалд 690 албан хаагч ажиллаж байгаа нь нийт төрийн албан хаагчийн 12.0 хувь;
- Төрийн тусгай албан тушаалд 71 албан хаагч ажиллаж байгаа нь нийт төрийн албан хаагчийн 1.3 хувь;
- Төрийн үйлчилгээний албан тушаалд 4823 албан хаагч ажиллаж байгаа нь нийт төрийн албан хаагчийн 84.0 хувийг тус тус эзэлж байна.

Увс аймгийн 2013-2023 оны төрийн албан хаагчийн тоо, нийт хүн ам, идэвхтэй хүн ам, ажил эрхэлж буй хүн амд эзэлж байгаа хувь

Хүснэгт 3.

№	Он	Увс аймгийн амын тоо	Идэвхтэй хүн ам	Ажил эрхэлж байгаа хүний тоо	Нийт төрийн албан хаагчийн тоо	Төрийн албан хаагчийн эзэлж буй хувь			Өсөлтийн хувь	
						Нийт хүн амд	Идэвхтэй хүн амд	Ажил эрхэлж байгаа хүн амд	Нийт хүн амын	ТАХ-ийн
1	2013	75518	37334	33559	4505	6.0	12.1	13.4		
2	2014	75737	34231	29174	4676	6.2	13.7	16.0	0.3	3.8
3	2015	80396	38502	35224	4902	6.1	12.7	13.9	6.2	4.8
4	2016	81377	36580	31381	4876	6.0	13.3	15.5	1.2	-0.5
5	2017	82604	38230	33261	4819	5.8	12.6	14.5	1.5	-1.2
6	2018	83617	36436	32712	4658	5.6	12.8	14.2	1.2	-3.3
7	2019	82946	34872	32568	4958	6.0	14.2	15.2	-0.8	6.4
8	2020	84294	34667	30788	5173	6.1	14.9	16.8	1.6	4.3
9	2021	85314	49533	47480	5170	6.1	10.4	10.9	1.2	-0.1
10	2022	85478	32870	29928	5690	6.7	17.3	19.0	0.2	10.1
11	2023	84976	34504	32426	5741	6.8	16.6	17.7	-0.6	0.9

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны мэдээ, Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайлангууд

Бүлэг 1

Төрийн байгууллагын хүний нөөцийн тогтолцоо нь төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэхэд чиглэгдэж байгаа ч хууль, тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна.

- 1.1. **Төрийн байгууллагуудын хүний нөөцийн асуудлыг зохицуулж буй хууль тогтоомж, баримталж буй бодлогын зорилт арга хэмжээ нь нэгдмэл, харилцан уялдаатай, бүх талын оролцоог хангаж чадаж байна.**
- 1.1.1. **Төрийн байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц нь Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцэж байна.**

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “30 хүртэл жилийн хугацаанд хэрэгжүүлэх “Алсын хараа” нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг байна”, 6.7 дахь хэсэгт “Дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна”, 6.8 дахь хэсэгт “Дунд хугацааны буюу дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр байна” гэж заасан байна.

Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Төрийн байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн талаар дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

Хүснэгт 4.

Алсын хараа 2050 МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг	МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Шинэ сэргэлтийн бодлого
Зорилт 5: Засаглал Зорилт 5.1-д Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана 5.2-д Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна 5.3-д Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг	Зорилт 5 “Засаглал” Зорилт 5.1-д Эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэртэй байдал, түүнд тавих хяналтыг оновчтой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, тогтвортой, хяналттай засаглалыг төлөвшүүлнэ 5.2-д Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн зааг, ялгааг оновчтой тодорхойлж, оролцоог зохистой хангасан, иргэдээ сонсдог, хувийн хэвшилтэйгээ хамтарч ажилладаг тогтолцоог бий болгоно 5.3-д Мэдээллийн	Зорилго 4: Засаглалын бодлого: “Цахим Монгол”-төрийн шуурхай үйлчилгээ 4.1.Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба 4.2.Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно. 4.2.2.Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн	Зорилт 6: Төрийн бүтээмжийн сэргэлт Зорилт 6.1-д Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна 6.2-д Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтад цогц шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч, оновчтой бүтцийг тогтоон, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ 6.4-д Төрийн

төлөвшүүлнэ 5.4-д Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ	аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлнэ 5.4-д Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ	иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах бодлогын шинэчлэлийг эхлүүлнэ. 4.2.6.Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагчийн сургалтын байгууллагын материаллаг орчныг сайжруулж, орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын орчин, дэд бүтэц бий болгоно.	өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна 6.5-д Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгана
---	--	--	--

Увс аймгийн түвшинд мөрдөх Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр байхгүй байна. Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/01 дүгээр тогтоолоор баталсан “Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 4/02 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т хүний нөөцийн бодлогыг дараах байдлаар тусгасан байна.

Хүснэгт 5.

Д/д	Дунд хугацааны бодлогын баримт бичгийн нэр	Зорилго	Зорилт	Хүрэх үр дүн
1	Аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/01 дүгээр тогтоолоор баталсан “Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”	Зорилго 5: Цахим технологид суурилсан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг бүх хүрээнд өргөжүүлэн, хүний эрхийг хангасан шударга ёсны тогтолцоо төлөвшүүлэх, авлигагүй аймаг болно.	5.4-д Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.	5.4.2-д Улс төрийн намд үйлчилдэггүй, хараат бус төрийн албыг бий болгож, төрийн албан хаагч тогтвортой ажиллах, төрийн албаны шатлах дэвшүүлэх тогтолцоог хэрэгжүүлнэ. 5.4.4-д Төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих таатай орчныг бүрдүүлнэ.
2	Аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/02 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”	Зорилго 4: Засаглалын бодлого: “Цахим Увс” төрийн шуурхай үйлчилгээ /Иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем/ Мэргэшсэн хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлнэ.	4.1-д Мэдээллийг аюулгүй байдлыг хангасан, цахим бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэн, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ. 4.2-д Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн,	Зорилт 4.1-ийн хүрээнд 4.1.1-4.1.7-д заасан ажлыг хийж хэрэгжүүлэхээр, Зорилт 4.2-ын хүрээнд 4.2.1-4.2.8-д заасан ажлыг хийж хэрэгжүүлэхээр тусгасан байна.

			тогтвортой төрийн албыг бэхжүүлж, Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, чиг үүргийн уялдааг хангах замаар үйлчилгээний үр дүн, нөлөөг дээшлүүлнэ.	
--	--	--	---	--

Эх сурвалж: /Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд/

Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичгийн хүрээнд зарим байгууллагууд үйл ажиллагааны дунд хугацааны стратеги боловсруулан, зарим байгууллага жилийн гүйцэтгэлийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд холбогдох зорилт, арга хэмжээг тусган, дэд хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Төсөвт байгууллагуудын бүтэц, орон тоог Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт нийцүүлэн тогтоосон жишиг нормын дагуу салбар яам, агентлаг, аймгийн Засаг дарга, нутгийн өөрөө удирдах байгууллага болох шат шатны ИТХ-ын бүтэц, орон тоог өөрсдөө, Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн хувьд ТУЗ-өөс нь тус тус баталж байна.

1.1.2. Батлагдсан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг Боловсрол, Эрүүл мэнд, Соёлын салбарт бүрэн мөрдөхгүй байна.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудад батлагдсан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэцтэй холбоотой дараах асуудал байна. Үүнд:

- ✓ Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 415 дугаар тушаалаар “Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэл”-ийг баталж, 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/37 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Тухайн үлгэрчилсэн бүтэцэд Нийгмийн эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн газраас тусгай статустай байхаар тусгасан байхад аймгийн Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тоонд Нийгмийн эрүүл мэндийн төв нэршилтэйгээр 11 ажилтан ажиллаж байна. Мөн Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсантай холбоотойгоор шилжиж ирсэн Эрүүл ахуйн чиглэлийн хяналтын улсын байцагч нар Эрүүл мэндийн газрын “Хяналт шалгалтын хэлтэс” болж бүтэц, орон тоонд батлагдсан байхад үлгэрчилсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.
- ✓ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дүгээр тушаалаар “Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргаа удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”-ыг баталсан байна. Орон тооны жишиг нормативаар сурагчийн тоо 641-ээс дээш хэдэн ч хүүхэдтэй байсан Ерөнхий боловсролын сургуульд сургалтын менежер 3 байхаар заасан байхад Улаангом сумын Ерөнхий боловсролын сургуулиудын хүүхдийн тоо, менежерийн орон тоо дараах байдалтай байна.

Хүснэгт 6.

Д/д	Сургуулийн нэр	Сурагчийн тоо	Менежерийн тоо
1	Улаангом сумын Ерөнхий боловсролын цогцолбор 1-р сургууль	3471	7
2	Улаангом сумын Ерөнхий боловсролын цогцолбор 2-р сургууль	2572	5
3	Улаангом сумын Ерөнхий боловсролын 3-р сургууль	1212	4
4	Улаангом сумын Ерөнхий боловсролын 4-р сургууль	945	3

5	Улаангом сумын Ерөнхий боловсролын 5-р сургууль	464	2
6	Улаангом сумын Ерөнхий боловсролын 6-р сургууль	1374	3

Эх сурвалж: /Аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын статистик мэдээ/

- ✓ Монгол улсын MNS 6981:2022 “Соёлын төв, соёлын ордон, орчин ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага”-ыг 2022 онд баталсан байна. Уг стандартын 4.5-д байгууллагын хүний нөөцөд тавих шаардлага, 4.5.1-д “Байгууллага нь хууль ёсны зорилгоо хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, орон тоотой байна”, 4.5.2-д “Байгууллагын орон тоог үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэлийн гол үзүүлэлт, үр дүн, байгууламжийн хүчин чадал зэргийг харгалзан тогтооно” гэж заажээ. Стандартын F хавсралт: Байгууллагын орон тооны жишигт зааснаар 250 хүртэл үзэгчийн суудалтай Соёлын төв 11-19 орон тоотой байхаар тусгасан байхад сумдын Соёлын төвүүдэд 6-7 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.
- ✓ Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар “Аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газрын зохион байгуулалтын бүтэц, дүрэм батлах тухай” тушаал гарсан байна. Засгийн газрын 2024 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар “Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” тогтоолоор Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудалд өөрчлөлт орсонтой холбоотойгоор Тухайн байгууллагын нэршил “Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар” болж өөрчлөгдсөн ч зохион байгуулалтын бүтэц, дүрэм, ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулаагүй, Соёлын сайдын 2022 баталсан бүтцээр ажиллаж байна.
- ✓ Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн “Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай” А/85, А/34 дүгээр тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн Хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилтны орон тооны хязгаарын жишиг нормативыг баталсан байна. Тухайн орон тооны хязгаар жишиг нормативыг орон нутагт мөрдөж эхлээгүй байна.

Аудитын түүвэрт хамрагдсан бусад байгууллагын хувьд батлагдсан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг мөрдөн ажиллаж байна.

1.1.2.1. Орон нутгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөрийг боловсруулж, баталгаажуулан хэрэгжүүлэх чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Аймгийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна”, 21.1.6 дахь заалтад “Аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр” гэж тусгасан байна.

Орон нутагт хэрэгжүүлэх хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөрийг боловсруулаагүй байна.

Аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг холбогдох албан тушаалтанд зөвлөмж болгов.

1.1.2.2. Аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүргээ аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлж байна.

Аймгийн түвшинд мөрдөх Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөрийг боловсруулаагүй байна. Харин Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/01 дүгээр тогтоолоор баталсан “Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 4/02 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т хүний нөөцийн бодлогын талаар зүйл, заалт тусгасан байна. Дунд хугацааны бодлогын баримт бичгийн биелэлтийг жил бүр аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж байна.

1.1.2.3. Сумд нь аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилт, ажиллах нөхцөлийн чиг үүргийг сумын дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан байна.

Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд сумдын таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна.

1.1.3. Урт, дунд хугацааны бодлогын зорилтыг хэрэгжүүлэх олон талын уялдаа холбоо хангагдаж, биелэлтэд ахиц, дэвшил гарч байна.

Урт, дунд хугацааны бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд дараах стандарт, дүрэм, журам, эрх зүйн актуудыг мөрдөж байна. Үүнд:

Боловсролын салбарын хувьд:

- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дүгээр тушаалаар “Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргаа удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”-ыг баталсан байна.
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/491 дүгээр тушаалаар Сургалтын төлөвлөгөө шинэчлэн баталснаар Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангиудын шаардлагатай багшийн орон тоог баталсан байна.
- 2013 оноос аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын бүтэц, орон тоог аймгийн Засаг дарга баталж байсан бөгөөд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/125 дугаар тушаалаар аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын орон тооны жишгийг баталжээ.
- Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/61 дүгээр тушаалаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/125 дугаар тушаалын хавсралтыг шинэчлэн баталсан байна.
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/137 дугаар тушаалын 18 дугаар хавсралтаар Увс аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын бүтэц, орон тоог баталж, Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудалд өөрчлөлт орсонтой холбоотойгоор Боловсролын сайдын 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/30 дугаар тушаалаар дахин өөрчлөлт оруулжээ.
- Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудалд өөрчлөлт орсонтой холбоотойгоор Боловсролын сайдын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/45 дугаар тушаалаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/578 дугаар тушаалаар баталсан “Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн үйл ажиллагааны журам”-д өөрчлөлт оруулсан байна.
- Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн шинэчлэгдэн батлагдаж, Засгийн газрын 2024 оны 06 дугаар тогтоолоор аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрыг Боловсролын газар болгож өөрчилсөнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 351 дүгээр “Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулах тухай” тогтоол гарсан байна. Боловсролын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/66 дугаар тушаалаар аймгийн Боловсролын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрсөн нэмэлт өөрчлөлтийг оруулан шинэчлэн баталсан байна.
- Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн “Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай” А/85, А/34 дүгээр тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн Хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилтны орон тооны хязгаарын жишиг нормативыг баталсан байна.

Эрүүл мэндийн салбарын хувьд:

- Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан байна. Уг бодлогын 2.4.3-д Хүний нөөцийн чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан байна.
- Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 415 дугаар тушаалаар

“Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэл”-ийг баталж, 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/37 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

- Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 193 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг баталсан байна.

Соёлын салбарын хувьд:

- Монгол улсын MNS 6981:2022 “Соёлын төв, соёлын ордон, орчин ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага”-ыг 2022 онд баталсан байна. Уг стандартын 4.5-д “Байгууллагын хүний нөөцөд тавих шаардлага”, 4.5.1-д “Байгууллага нь хууль ёсны зорилгоо хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, орон тоотой байна”, 4.5.2-д “Байгууллагын орон тоог үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэлийн гол үзүүлэлт, үр дүн, байгууламжийн хүчин чадал зэргийг харгалзан тогтооно” гэж заажээ.
- Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар “Аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газрын зохион байгуулалтын бүтэц, дүрэм батлах тухай” тушаал гарсан байна.

Бусад аудитын түүвэрт хамрагдсан байгууллагын хувьд:

- Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсан байна.
- Төсөвт байгууллагууд сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр, дэд төлөвлөгөө боловсруулан мөрдөж байна.
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн А/147 дугаар тушаалаар “Салбарын хүний нөөцийн хөгжлийн дунд хугацааны стратеги”-ийг, 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/205 дугаар тушаалаар “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын стратеги төлөвлөгөө”-г тус тус батлан мөрдөж байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын бүтэц, орон тоог баталж байна.
- Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд бүтэц, орон тоог ТУЗ-өөс баталж байна.

1.1.4. Төрийн албаны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-үнэлгээ хийж, үр нөлөөг тооцож байна.

Төрийн албаны зөвлөлөөс 2021 онд Увс аймгийн төрийн байгууллагуудад хяналт, шалгалт хийж Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 240 дугаар “Хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоолыг ирүүлсэн байна.

Тогтоолын 2-д “Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 40 дүгээр хуралдаанаар Увс аймгийн төрийн захиргааны байгууллагуудад хяналт шалгалт хийсэн ажлын тайланг хэлэлцээд тус аймгийн төрийн захиргааны байгууллагуудын зарим удирдах, гүйцэтгэх албан тушаалд томилсон энэхүү тогтоолын 1-15 дугаар хавсралтад дурдсан шийдвэр Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 25 дугаар зүйлийн 25.1, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 33 дугаар зүйлийн 33.3, 42 дугаар зүйлийн 42.1, 43 дугаар зүйлийн 43.3, 44 дүгээр зүйлийн 44.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14, 15, 16, 17 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”, Монгол улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн хамтарсан 2019 оны 34/31 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын холбогдох заалтыг тус тус зөрчсөнийг тогтоосугай” гэж заасан байна.

Энэ тогтоолын хавсралтаар 15 байгууллагын 75 албан хаагчид холбоотой зөрчил илрүүлсэн байх бөгөөд Төрийн албаны зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөлөөс 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар тогтоолын хавсралтад заасан 75 зөрчлийн 73 зөрчлийг арилгаж биелэлт 97.3 хувьтай гэж

тайлан хүргүүлсэн байна.

Төрийн албаны зөвлөлөөс 2024 онд Увс аймгийн төрийн байгууллагуудад хяналт, шалгалт хийж Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 172 дугаар “Хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоолыг ирүүлсэн байна.

Тогтоолын 1-д “Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 17 дугаар хуралдаанаар Увс аймгийн төрийн захиргааны байгууллагуудын төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, зөвлөн тусалсан ажлын хэсгийн тайланг хянан хэлэлцээд төрийн захиргааны зарим удирдах, гүйцэтгэх албан тушаалд томилсон шийдвэр Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 27 дугаар зүйлийн 27.1, 33 дугаар зүйлийн 33.3, 42 дугаар зүйлийн 42.1, 43 дугаар зүйлийн 43.3, 44 дүгээр зүйлийн 44.1, 44.3-т заасныг тус тус зөрчсөнийг тогтоосугай” гэж заасан байна.

Энэ тогтоолын хавсралтаар 5 байгууллагын 7 албан хаагчид холбоотой зөрчил илрүүлсэн бөгөөд Төрийн албаны зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөлөөс 6 зөрчлийг бүрэн арилгасан биелэлт 85.7 хувьтай гэж тайлан хүргүүлсэн байна.

Төрийн албаны зөвлөлийн даргын 2024 оны 136 дугаар тушаалаар “Төрийн байгууллагын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүн” сэдвээр яам, агентлаг, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад хүний нөөцийн аудит хийх багийг томилсон байна.

Аудитын хүрээнд Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжлийн бодлого, арга хэмжээний явц, үр дүнг тооцож, дүгнэлт өгөх, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, шийдвэр гаргуулах зорилгоор Увс аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлөөс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын эрхлэх хүрээний асуудал хариуцсан 20 агентлаг, аймгийн төвийн сум болох Улаангом сумын Засаг даргын Тамгын газар зэрэг байгууллагад ажилласан байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсээс аймгийн Засаг даргын 2022 оны А/06 дугаар захирамжаар баталсан “Хяналт шинжилгээ, үнэлгээний аргачлал”-ын дагуу жил бүр хяналт шинжилгээг агентлаг, сумдын төсөвт байгууллагуудад хийсэн байна. Тухайн аргачлалын хүрээнд сумдын болон агентлагийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 8-10 үзүүлэлтээр хяналт үнэлгээ хийж зөвлөмж, чиглэл өгч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

1.2. Төрийн байгууллагын хүний нөөцийн тогтолцоо нь төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэхэд чиглэгдэж байгаа ч Төрийн байгууллагуудын төсвийн хүрэлцээгүй байдал, албан тушаалын тодорхойлолт батлагдахгүй байгаа нь нөөцийн хуваарилалтад нөлөөлж байна.

1.2.1. Төрийн байгууллагуудад хүний нөөцийн хүрэлцээ харилцан адилгүй байна.

Аймгийн түвшинд 5741 төрийн албан хаагч байгаагаас 157 улс төрийн, 690 төрийн захиргааны, 71 төрийн тусгай, 4823 нь төрийн үйлчилгээний албан хаагч байна. Төрийн албан хаагчийн нөөцөд 2023 оны байдлаар 357 иргэн бүртгэлтэй байна.

Төрийн албаны Увс аймаг дахь салбар зөвлөлийн судалгаагаар төрийн байгууллагуудад дараах мэргэжлийн ажилтан дутагдалтай байна. Үүнд:

➤ Төрийн захиргааны албан тушаалд 3 чиглэлийн 25 орон тоо дутагдалтай байна. Үүнд: Малын

эмч, мал зүйч, газар зохион байгуулалт, газрын кадастр, хүнс, хөдөө аж ахуйн мэргэжилтэн гэх мэт,

- Соёлын салбарт 14 мэргэжлийн нийт 25 орон тоо дутагдалтай байна. Үүнд: Бүжгийн багш, соёлын өвийн ажилтан, хөгжмийн багш, найруулагч гэх мэт,
- Боловсролын салбарт СӨБ-ийн 11 чиглэлийн 67 орон тоо дутагдалтай байна. Үүнд: Биеийн тамирын багш, бүлгийн багш, хөгжмийн багш, ЕБС-ийн 19 чиглэлийн 69 орон тоо дутагдалтай байна. Үүнд: Бага ангийн багш, газар зүй, физик, математик, мэдээлэл технологи, сэтгэл зүйч, технологийн эрэгтэй, эмэгтэй багш гэх мэт,
- Эрүүл мэндийн салбарт 10 чиглэлийн 39 орон тоо дутагдалтай байна. Үүнд: Багийн эмч, их эмч, сувилагч, уламжлалтын эмч гэх мэт ажлын байранд ажилтан дутагдалтай байна.

Аудитын явцад төсвийн байгууллагуудтай уулзалт ярилцлага хийхэд батлагдсан бүтэц орон тоондоо багтааж төрийн үйлчилгээг үзүүлж байгаа боловч цаашид нэн тэргүүнд шаардлагатай дараах орон тоо байгаа талаар санал өгсөн Үүнд:

- Сумдын Ерөнхий боловсролын сургуулиудад сургалтын менежер, хоол зүйч, сэтгэл зүйч, бичиг хэргийн ажилтны орон тоо,
- Сумдын Хүүхдийн цэцэрлэгт биеийн тамирын багш, дуу хөгжмийн багш, хоол зүйч, эмч, цагаан хэрэгсэл угаагчийн орон тоо,
- Сумдын соёлын төвд өвийн ажилтан, бичиг хэргийн ажилтны орон тоо,
- Насан туршийн суралцахуйн төвд Нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн орон тоо,
- Сумдын ЗДТГ-т Хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтний орон тоо.

1.2.2. Төрийн байгууллагын үйлчилгээ нь иргэдэд ил тод нээлттэй байна.

Цахим засаглалыг бэхжүүлэх Дижитал-Увс аймаг арга хэмжээг 2023 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газраас “Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног-2024” арга хэмжээг “Мэдээллийн хүртээмж, цахим засаглал, олон нийтийн оролцоо” сэдвийн хүрээнд, төрийн цахим үйлчилгээ (e-mongolia) болон иргэн төр, хувийн хэвшлийн харилцааг түргэн шуурхай, хүнд сурталгүй хүргэх 12 төрлийн цахим шийдэл бүхий “Дижитал-Увс аймаг” иргэний аппликейшнийг танилцуулах, хэрэглээг нэмэгдүүлж, иргэдийнхээ цахим боловсролыг дэмжихэд чиглүүлж зохион байгуулсан байна.

Аймгийн түвшинд орон нутгийн телевиз болон мэдээллийн нэгдсэн дашбоард, аймгийн нэгдсэн сайт www.uvs.gov.mn, “Миний Увс” фэйж хуудас, “Дижитал Увс аймаг” иргэний аппликейшнээр, төсөвт байгууллагууд вэбсайт, фэйсбүүк цахим хуудсаар иргэдэд мэдээ, мэдээллийг тогтмол хүргэж, үйл ажиллагааны ил тод байдлын мэдээллийг Shilendans.gov.mn цахим сайтад байршуулан ажиллаж байна.

Орон нутагт хэрэгжүүлэх “Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”-ыг аймгийн Засаг даргын 2017 оны А/281, 2021 оны А/166 дугаар тушаалуудаар тус тус батлан мөрдөж байсныг Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/06 дугаар захирамжаар шинэчлэн баталсан байна. Энэхүү аргачлалын 5, 6 дугаар хавсралтад заасан агентлагийн болон сумдын ажлыг үнэлж дүгнэх үзүүлэлтийн дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс жил бүр 3 ангиллын 19-20 үзүүлэлтээр үнэлгээ хийж байна.

Үнэлгээний маягтын 3-д “Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ”-г тусгаж, энэ хүрээнд 2021 он хүртэл шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, байгууллагын ил тод байдлын үнэлгээ, шударга байдлын түвшний үнэлгээ гэсэн үзүүлэлтээр, 2021 оноос шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үнэлгээ, шинэлэг болон бусдад түгээх сайн туршлага /онцлох ажил/-ын үнэлгээ гэсэн үзүүлэлтээр төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдалд хяналт хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын ил тод, нээлттэй байдлын үнэлгээг сүүлийн 4 жилээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 7.

Д/д	Агентлаг, сумд	Ил тод байдлын үнэлгээ											
		Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үнэлгээ				Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ				Шударга байдлын түвшний үнэлгээ, шинэлэг болон бусдад түгээх сайн туршлага /онцлох ажил/-ын үнэлгээ			
		2020	2021	2022	2023	2020	2021	2022	2023	2020	2021	2022	2023
1	Баруунтуруун	75.4	70	69	62	100	85	96	100	90	100	70	90
2	Бөхмөрөн	74.2	70	81	65	96.1	85	87	99	70	90	80	80
3	Давст	76.9	70	72	55	100	85	99	89	70	100	80	80
4	Завхан	77.9	70	79	61	99	85	96	98	70	100	70	70
5	Зүүнговь	81.9	70	55	50	100	89	86	89	70	0	0	60
6	Зүүнхангай	84.4	70	91	73	100	90	97	89	90	90	70	80
7	Малчин	76.3	70	84	55	98.7	92	88	99	70	100	80	70
8	Наранбулаг	82.4	70	77	70	100	97	90	100	70	90	70	90
9	Өлгий	68.8	70	81	65	96	92	91	99	70	100	90	90
10	Өмнөговь	80.8	70	82	65	100	90	94	99	70	100	90	95
11	Өндөрхангай	83.1	70	84	90	100	90	97	100	70	100	90	95
12	Сагил	82.4	70	86	60	100	90	92	99	70	100	80	80
13	Тариалан	82.4	70	67	70	100	97	99	99	70	90	100	80
14	Түргэн	79.8	70	67	45	98	96	94	100	70	80	0	70
15	Тэс	71.9	70	72	77	100	90	88	99	70	95	100	95
16	Ховд	79.7	70	93	55	100	90	93	89	70	50	60	60
17	Хяргас	75	70	81	60	100	90	89	89	70	90	70	70
18	Цагаанхайрхан	79.4	70	65	55	99.6	87	99	98	70	100	80	70
19	Улаангом	83	70	73	83	94.6	90	95	100	70	90	80	70
20	Байгаль орчин аялал жуулчлалын газар	67.8	50	75.6	60	98.7	100	100	99.8	70	70	0	90
21	Биеийн тамир спортын газар	34.4	100	86	71	98.7	100	96	99.8	70	90	0	50
22	Боловсролын газар	80	100	86.3	60	100	100	100	99.9	70	100	95	90
23	Гаалийн газар	-	30	-	55	98	98.6	97.3	100	70	0	0	-
24	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	64.4	100	92	81	97.8	98.6	100	99.9	90	70	0	70
25	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар	56.6	70	64.6	60	100	96	98.7	80	70	0	0	50
26	Мал эмнэлгийн газар	70	30	71	70	99.9	99.3	86.1	99.9	70	0	0	50
27	Мэргэжлийн хяналтын газар	83.3	100	-	-	99.9	99.3	-	-	90	0	-	-
28	Нийгмийн даатгалын хэлтэс	64.4	70	73.3	73	99.3	92.6	95.3	99.5	95	100	70	80
29	Онцгой байдлын газар	90	50	55	65	100	99.3	100	99.9	90	70	0	50
30	Орон нутгийн өмчийн газар	56.6	70	90	80	98.7	87.3	93.3	80	90	0	70	70
31	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	67.7	70	96	80	100	93.2	99.3	99.8	90	0	95	70
32	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	-	-	66	55	-	-	100	99.9	-	-	0	70
33	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	75.5	70	90.9	63	99.9	93.9	100	100	70	70	0	80
34	Статистикийн хэлтэс	76.6	100	70	75	100	99.3	100	99.9	70	100	90	50
35	Татварын хэлтэс	68.8	70	72.3	65	99.2	96.6	100	99.9	70	0	60	50
36	Улсын бүртгэлийн хэлтэс	64.4	100	60	91	99.9	98.6	100	99.9	70	0	60	50
37	Ус цаг уур орчины шинжилгээний алба	67.7	70	80	70	100	98.6	100	99.7	70	0	0	50
38	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар	60	100	96.6	96	94	85.2	97.3	85	90	90	90	80
39	Хүнс хөдөө аж ахуйн газар	72.2	70	88	65	94.8	70.1	96	80	90	100	90	95
40	Цагдаагийн газар	80	100	70	96	100	100	100	100	70	90	100	50
41	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	66.7	70	68	65	100	97.9	92.6	100	70	0	0	50
42	Шүүхийн шинжилгээний алба	65.5	70	55	70	99.8	92.6	98	100	70	0	0	50
43	Эрүүл мэндийн газар	80	70	87	60	99.4	97.9	98	99.9	70	100	80	90
44	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	-	-	68	55	-	-	86.4	-	-	-	0	50

Эх сурвалж: /Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс/

Судалгаанаас нэгтгэн үзэхэд байгууллагын ил тод, нээлттэй байдлын үнэлгээгээр агентлаг, сумууд дараах байдлаар үнэлэгдсэн байна. Үүнд:

- 2020 онд сумдын дундаж үнэлгээ 83.3 хувь, агентлагийн дундаж үнэлгээ 81.7 хувь,
- 2021 онд сумдын дундаж үнэлгээ 82.5 хувь, агентлагийн дундаж үнэлгээ 66.7 хувь,
- 2022 онд сумдын дундаж үнэлгээ 80.5 хувь, агентлагийн дундаж үнэлгээ 70.5 хувь,
- 2023 онд сумдын дундаж үнэлгээ 79.7 хувь, агентлагийн дундаж үнэлгээ 77.1 хувь

Аудитын явцад 300 гаруй иргэдээс санал асуулга авахад дараах байдлаар хариулсан байна. Үүнд:

- Төрийн байгууллагын үйлчилгээ иргэдэд ил тод хүрч байна уу? гэсэн асуултад тийм гэж 264 иргэн, үгүй гэж 36 иргэн хариулсан байна.
- Төрийн үйлчилгээг цахимаар авч чадаж байна уу? гэсэн асуултад тийм гэж 264, үгүй гэж 32 иргэн хариулсан байна.

1.2.3.Төрийн байгууллагуудын төсвийн хүрэлцээгүй байдал, албан тушаалын тодорхойлолт батлагдаж ирээгүй зэрэг нь нөөцийн хуваарилалтад нөлөөлж байна.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагууд батлагдсан бүтэц, орон тооны хүрээнд тухайн ажлын байранд тавигдах албан тушаалын тодорхойлолтын дагуу нөөцийн хуваарилалтыг хийж байна.

- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/137 дугаар тушаалын 18 дугаар хавсралтаар Увс аймгийн Боловсролын газрын бүтэц, орон тоог 32 байхаар баталж ирүүлсэн боловч 24 ажилтантай байна. Учир нь бүтэц орон тоотой уялдуулан төсөв санхүүжилт батлагдаагүйгээс батлагдсан ажлын байранд шинээр ажилтан авах боломжгүй байна. Мөн биеийн тамир, дуу хөгжмийн арга зүйчийн ажлын байранд 2022 оноос хойш 5 удаа сонгон шалгаруулалт зарлуулахаар Төрийн албаны зөвлөлд хүсэлт хүргүүлж, зарласан боловч хүн оролцоогүйгээс 2 орон тоо дутуу ажиллаж байна.
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2023 оны А/15 дугаар тушаалын 18 дугаар хавсралтаар Увс аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын бүтэц, орон тоог 67 албан хаагчтайгаар баталжээ. Хөдөлмөрийн хяналт, эрүүл ахуйн улсын байцаагчийн ажлын байранд албан тушаалын тодорхойлолт батлагдаж ирээгүйгээс сонгон шалгаруулалт зарлаагүй 2023 оны 1 сараас хойш сул байна.
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар сумдын хүн амын тооноос хамааруулан нөөцийн хуваарилалт хийснээр 19 суманд нийт 23 мэргэжилтэн ажиллаж байна. Үүнд: Улаангом сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн 4, Тэс суманд 2 мэргэжилтэн, бусад 17 суманд тус бүр 1 мэргэжилтэн ажиллаж байна.
- Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан бүтэц орон тоонд үйлчлэгч 3 гэж заасан байхад 4 үйлчлэгч ажиллуулж байна.
- Өмнөговь сумын ЗДТГ-ын бэлчээр газар тариалан хариуцсан ажилтны ажлын байранд сонгон шалгаруулалт зарласан боловч оролцогч ороогүй тул орон тоо сул байна.
- Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 415 дугаар тушаалаар "Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэл"-ийг баталж 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/37 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Тухайн үлгэрчилсэн бүтцэд аймгийн Эрүүл мэндийн газар нь яг хэдэн орон тоотой байх талаар тодорхой тусгаж өгөөгүй байна. Уг байгууллага бүтэц, орон тоогоо аймгийн Засаг даргаар батлуулж байх бөгөөд Эрүүл мэндийн газрын батлагдсан бүтэц, орон тоо нь 2020 онд 33 байсан бол 2024 онд 51 болж 18 орон тоогоор нэмэгдүүлсэн байна. Сангийн яамнаас 40 орон тооны санхүүжилтийг баталсан ч гүйцэтгэлээр 45 албан хаагч ажиллаж байна. Тухайлбал: Удирдлага, төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга, Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн даргын сул орон тоо байна.
- Аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/104 дүгээр захирамжаар "Санхүүгийн хяналт, аудитын алба"-ыг "Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба" болгон өөрчилж 10 орон тоотой байхаар баталсан ч 8 орон тоогоор ажиллаж байна. Албаны дарга, дотоод аудиторын 2 орон тоо сул байна.
- Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/703 дугаар захирамжийн 3-р хавсралтаар Орон нутгийн өмчийн газрын бүтэц, орон тоог 12 байхаар баталсан боловч төсөв хүрэлцээгүй шалтгаанаар 6 хүн ажиллаж байна.
- Аймгийн ИТХ нь 2024 онд бүтэц, орон тоог батлахдаа даргын туслах архив бичиг хэрэг хариуцсан ажилтан-1, жолооч нярав-1 гэсэн төрийн үйлчилгээний 2 орон тоог архив, бичиг хэргийн ажилтан-1, даргын туслах, нярав-1, жолооч-1 гэсэн 3 орон тоо болгон нэмэгдүүлж Засгийн газраас тогтоосон хязгаараас хэтрүүлэн баталжээ.
- Аймгийн ИТХ нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 15-ны А/112 тоот тушаалыг үндэслэн ИТХ-ын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Б/05 дугаар тушаалаар бүтэц, орон тоонд батлагдаагүй шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газрын орон нутаг хариуцсан улсын байцаагчаар П.Аюушжавыг томилсон байна. Улмаар ИТХ-ын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн Б/20 дугаар тушаалаар бүтэц, орон тоонд батлагдаагүй аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилж 2022 оны 3 дугаар сар хүртэл бүтэц, орон тоонд батлагдаагүй албан тушаалд ажиллуулсан байна.

Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд дараах тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлж болно”, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 43.3.1-д зааснаас бусад тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан 14 хоногийн дотор гаргана”, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт “Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно” гэж заасны дагуу аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудад гарсан сул орон тоонд нөөцийн хуваарилалтыг хийж байна. Тухайлбал: сумдын ЭМТ-ийн хувьд багийн эмч, уламжлалтын эмч, эх баригч, хүүхдийн эмч, дотрын эмч, вакцинатор, Соёлын төвийн хувьд бүжгийн багш, хөгжмийн багш, өвийн ажилтан гэх мэт орон тоо дутагдалтай байна.

Сангийн яамнаас төсөв батлахдаа тухайн байгууллагын батлагдсан бүтэц орон тоотой уялдуулах, ТАЗ нь ажлын байрны албан тушаалын тодорхойлолтыг хүсэлт хүргүүлэх бүрд шийдвэрлэж байх саналуудыг УАГ-ын нэгтгэл тайланд тусгуулахаар санал хүргүүлж байна.

1.3. Төрийн байгууллагын хүний нөөцийн удирдлагын үр дүн хангалтгүй байна.

1.3.1. Ерөнхий боловсролын 27 сургуулиас бусад төрийн байгууллагуудад эрх бүхий байгууллагаас чиг үүргийн шинжилгээ хийж, албан тушаалын давхардал, хийдлийг арилгах арга хэмжээ аваагүй байна.

Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолын хавсралтаар “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ыг баталсан байна.

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2019 онд албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлахаар төрийн бүх байгууллагууд ажлын байрны шинжилгээ хийж албан тушаалын тодорхойлолт боловсруулсан байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А/024/11 дүгээр тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/491 дүгээр тушаалын хүрээнд аймгийн Боловсролын газраас салбарын байгууллагуудад ажлын байрны чиг үүргийн шинжилгээ хийж, аймгийн төвийн болон хөдөөгийн сумдын нийт 27 Ерөнхий боловсролын сургуулийг хамруулжээ.

Шинжилгээгээр Сангийн сайдын хамтарсан 2018 оны А/024/11 дүгээр тушаалаар батлагдсан орон тооны нормативаас нийт 30 орон тоо илүүдэлтэй, 10 орон тоо дутагдалтай байжээ. Үүнд:

- ✓ Сургалтын менежер 9, нийгмийн ажилтан 1, нягтлан бодогч 2, нярав 2, эмч 6, сантехникч 4, цахилгаанчин 1, жижүүр манаач 1, сэтгэл зүйч 1, хоол зүйч 3, нийт 30 орон тоо илүүдэлтэй,
- ✓ Хичээлийн зохицуулагч 1, тогооч /үдийн хоол/ 4, үйлчлэгч 2, дотуур байрны үйлчлэгч 3, нийт 10 орон тоо дутагдалтай байсан байна.

Дээрх шинжилгээний үр дүнг Ерөнхий боловсролын сургууль бүрээр нь гаргаж зөвлөмж, чиглэл өгсөн байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/02 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.1-д “Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн

шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгох, ажил үүргийн давхцалыг арилгах бодлогын шинэчлэлийг эхлүүлэх” гэж тусгасан боловч чиг үүрэгт шинжилгээ хийж, албан тушаалын давхардал, хийдлийг арилгах арга хэмжээ аваагүй байна. Мөн бусад аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудад эрх бүхий байгууллагаас төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийж, албан тушаалын давхардал, хийдлийг арилгах арга хэмжээ авсан асуудал байхгүй байна.

1.3.1.1. Төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийх эрх зүйн орчин бүрдсэн байна.

Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт “Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 66.1.7 дахь заалтад “Чиг үүргийн шинжилгээ хийхэд төрийн байгууллагад мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх” гэж тусгажээ.

Төвлөрлийг сааруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагын (цаашид “төрийн байгууллага” гэх) чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийсний үндсэн дээр зарим чиг үүргийг засаг захиргааны түвшин буюу тодорхой салбар хооронд, эсхүл төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлэхэд мөрдөгдөх “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ыг Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан байна.

Мөн аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1-д “Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгох, ажил үүргийн давхцалыг арилгах бодлогын шинэчлэлийг эхлүүлэх” гэж тусгажээ.

1.3.1.2. Төрийн байгууллагын чиг үүрэгт аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсээс шинжилгээ хийсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсээс аймгийн Засаг даргын 2022 оны А/06 дугаар захирамжаар баталсан “Хяналт шинжилгээ, үнэлгээний аргачлал”-ын дагуу жил бүр хяналт шинжилгээг агентлаг, сумдын төсөвт байгууллагуудад хийж байна. Тухайн аргачлалын хүрээнд агентлаг, сумдын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээг 4-7 үзүүлэлтээр үнэлдэг байна.

Аймгийн Соёл, урлагийн газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр баталсан “Соёл урлагийн газрын харьяа байгууллагуудад дотоод хяналт шалгалт хийх, зөвлөн туслах ажлын удирдамж”-ийн дагуу аймгийн Музей, Ойрад хөгжимт жүжгийн театр, Нийтийн номын сан, Соёлын төвүүдийн 2022-2023 оны үйл ажиллагааг хамруулан хяналт шинжилгээ хийсэн байна.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудаас дараах 2 байгууллагад чиг үүргийн шинжилгээтэй холбоотой дараах зөрчил байна. Үүнд:

- Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тоог 2024 онд батлахдаа Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчийн 4 орон тооны нэгийг Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч гэж өөрчлөн баталсан байна. Гэтэл Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагчийн орон тоо нь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хамааралтай орон тоо байна. Ажлын байрны тодорхойлолтод заасан нэршлээр бүтэц, орон тоогоо батлахыг аймгийн Эрүүл мэндийн газарт зөвлөв.
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн Б/02 дугаар захирамжаар Хурлын ажлын албаны хурлын зөвлөл, хороод, маркетинг хариуцсан албан тушаалд түр томилогдсон албан хаагч П.Аюушжавыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон байна. П.Аюушжав нь Хурлын ажлын албаны хурлын зөвлөл, хороод, маркетинг хариуцсан албан тушаалын тусгай шалгалтад хамрагдаж тэнцэж 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар өөрийгөө ажилд томилсон шийдвэр гаргасан байна. Цаашид

эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр томилгоо хийж байхыг зөвлөв.

1.3.1.3. Төрийн байгууллагын чиг үүрэгт хийсэн шинжилгээний үр дүнг үндэслэн арга хэмжээ авч байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсээс аймгийн Засаг даргын 2022 оны А/06 дугаар захирамжаар баталсан “Хяналт шинжилгээ, үнэлгээний аргачлал”-ын дагуу жил бүр хяналт шинжилгээг агентлаг, сумдын төсөвт байгууллагуудад хийж зөвлөмж чиглэл өгч, тухайн өгсөн үүрэг, чиглэлийн биелэлтийг дараа жил нь дахин хяналт хэрэгжүүлжээ.

Аймгийн Соёл, урлагийн газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр баталсан “Соёл урлагийн газрын харьяа байгууллагуудад дотоод хяналт шалгалт хийх, зөвлөн туслах ажлын удирдамж”-ийн дагуу аймгийн Музей, Ойрад хөгжимт жүжгийн театр, Нийтийн номын сан, Соёлын төвүүдийн 2022-2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээгээр зөвлөмж, чиглэл өгсөн байна.

1.3.1.4. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийн боловсруулалт, баталгаажуулалт, гүйцэтгэлд дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийн боловсруулалт, баталгаажуулалт, гүйцэтгэлд орон нутгийн түвшинд дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/08 дугаар захирамжийг үндэслэл болгож ЭМГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Б/01 дүгээр “Бүтэц орон тоо, цалин шинэчлэн тогтоох тухай” тушаал гаргасан нь цаглаврын хувьд зөрүүтэй байна. Цаашид тушаал шийдвэрийг цаглаврын хувьд үнэн зөв гаргаж байхыг зөвлөв.

1.3.1.5. Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсантай холбогдуулан албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагууд төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолтыг боловсруулахдаа төрийн албаны төв байгууллагын баталсан нийтлэг журмыг жишиг болгон мөрдөж байна.

Харин төсөвт байгууллагуудын зарим ажлын байрны тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөс батлаагүй байна.

Мөн төрийн захиргааны албан тушаалтнуудад мөрдөгдөж байгаа Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор батлагдсан албан тушаалын тодорхойлолт нь ажилтнуудын албан тушаалуудад мөрдөж байгаа албан тушаалын ангилал, зэрэглэлтэй нийцэхгүй шинэчлэх шаардлагатай байна. Тухайлбал: Улаангом сумын ЗДТГ-ын Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байрны хувьд ТА3-ийн баталсан албан тушаалын тодорхойлолтод албан тушаалын ангилал зэрэглэлийг Т3-3 байхаар тусгасан байхад одоо мөрдөгдөж байгаа шатлалаар Т3-9 ангилал зэрэглэлээр цалинжиж байна. Нийгмийн ажилтнууд ТА3-ийн баталсан албан тушаалын тодорхойлолтод албан тушаалын ангилал зэрэглэлийг Т3-1 байхаар тусгасан байхад одоо мөрдөгдөж байгаа шатлалаар Т3-10 ангилал зэрэглэлээр цалинжиж байна.

1.3.1.6. Төрийн байгууллагууд албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагад нийцсэн "албан тушаалын тодорхойлолт" боловсруулж, батлуулж чадахгүй байна.

Аудитын түүвэрт хамрагдсан төсвийн байгууллагуудад албан тушаалын тодорхойлолттой холбоотой дараах зөрчил байна. Үүнд:

- Аймгийн Эрүүл мэндийн газрын төрийн үйлчилгээний албан хаагчдаас 2 үйлчлэгчээс бусад ажилтны ажлын байрны тодорхойлолт байхгүй байна.
- Аймгийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн магадлан итгэмжлэл, тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн гэсэн албан тушаалын тодорхойлолтыг төрийн албаны зөвлөлөөр баталгаажуулаагүй байна.
- Завхан сумын ЭМТ-ийн даргын албан тушаалын тодорхойлолт байхгүй, бусад албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтын боловсруулалт хангалтгүй байна.
- Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь байгууллагын нэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Төрийн албаны зөвлөлд ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх хүсэлтийг 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 57 дугаар бичгээр хүргүүлсэн боловч батлагдаж ирээгүй байна. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын болон дотоод аудиторовын ажлын байрны тодорхойлолт байхгүй, байгууллагын бусад ажилтнууд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 128 дугаар тогтоолын дагуу батлагдсан ажлын байрны тодорхойлолтыг мөрдөж байна.
- Насан туршийн суралцахуйн төвийн захирлын болон ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт батлагдаж ирээгүй байна. Ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг байгууллагын түвшинд боловсруулан батлахдаа 8 ажлын байрны тусгай шаардлагад тухайлсан ажилтны ажилласан жил, мэргэжлийг шууд тусган баталсан нь тухайн хүнд нь зориулж баталсан гэж харагдаж байна. Тухайлбал: Албан тушаалын тодорхойлолтод Химийн багш мэргэжилтэй, Боловсролын салбарт 8 жил ажилласан байх, мөн Орос, Англи хэлний багш мэргэжилтэй, Боловсролын салбарт 33 жил ажилласан байх гэх мэтээр тусгажээ.
- Улаангом сумын ЗДТГ-т Төрийн албаны салбар зөвлөлд хүсэлт хүргүүлсэн боловч ажлын байрны тодорхойлолт нь батлагдаж ирээгүй гэх шалтгаанаар сонгон шалгаруулалт зарлагдаагүй Багийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн, Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн, Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Ногоон байгууламж, хог хаягдал хариуцсан мэргэжилтэн гэсэн 4 ажлын байр байна.
- Боловсролын газрын бүтэц, орон тоог 2020 оноос хойш нэршилтэй холбоотойгоор 4 удаа шинэчлэн тогтоож нэршил, шатлал, ангилал өөрчлөгдөхөд тухайн ажлын байрны тодорхойлолтод тухай бүр өөрчлөлт оруулж ирүүлээгүй байна. Албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөс шинэчлэн ирүүлээгүйгээс шалтгаалан ажлын байранд тавигдах шаардлага тодорхойгүй байдал үүсэж хүний нөөцөд бүртгэгдсэн хүнийг түр тушаалаар авдаг, тусгай шалгалт зарлах боломжгүй байна. Жишээ нь: Мэргэжилтний ажлын байрны нэршил ахлах мэргэжилтэн, хэлтсийн дарга болж тус тус өөрчлөгдөхөд мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтоор явж иржээ. Харин 2024 оны 8 сард ажлын байрны тодорхойлолтыг шинэ нэршлийн дагуу баталж ирүүлсэн байна.
- Өлгий сумын ЭМТ-ийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт байхгүй, Соёлын төвийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг баталж албажуулаагүй байна.
- Өмнөговь сумын ЭМТ-ийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт байхгүй байна.
- Наранбулаг сумын Соёлын төвийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт байхгүй, Хүүхдийн цэцэрлэг ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг баталж албажуулаагүй байна.
- Сагил сумын ЕБС-ийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг байгууллагын түвшинд өөрсдөө боловсруулж байна. Багшийн ажлын байрны тодорхойлолтод тавигдах мэргэжлийн тусгай шаардлагад юуны багшаас үл хамаарч багш мэргэжилтэй гэж заасан байна.
- Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсантай холбоотойгоор 2023 оны 01 дүгээр сард шилжиж ирсэн Эрүүл ахуйн чиглэлийн хяналтын улсын байцагч нар нь Эрүүл мэндийн газрын "Хяналт шалгалтын хэлтэс" болж бүтэц орон тоонд батлагдсан байна. Тухайн бүтцийн өөрчлөлтөөр ирсэн ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулаагүй хуучин Мэргэжлийн хяналтын газрын даргын тушаалаар баталсан албан тушаалын тодорхойлолттой ажиллаж байна.
- Эрүүл мэндийн газрын даргын Халдварт бус өвчний сэргийлэлт, хяналт хариуцсан мэргэжилтний албан тушаалд сонгон шалгаруулалт зарлахгүйгээр түр хүн томилж ажиллаж

байгаад ерөнхий болон тусгай шалгалт өгч жинхэлсэн байна. Тухайн ажлын байрны ажлын байрны тодорхойлолтын албан тушаалд тавигдах тусгай шаардлагаар мэргэжлээрээ 5-аас доошгүй жил, эсхүл туслах түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан иргэнийг томилохоор заасан байхад мэргэжлээрээ 1 жил ажилласан хүнийг авч ажиллуулсан байна.

- Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Б/66 дугаар тушаалаар Д.Түмэндэмбэрэлийг дархлаажуулалт хариуцсан их эмчээр 3 сарын хугацаатай түр томилсон байна. Тухайн ажилтан одоо хүртэл түр тушаалтай ажиллаж байна.
- Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн Б/05 дугаар тушаалаар Б.Эрдэнэбилэгийг тархавар судлал, эмнэлгээс шалтгаалах халдвар, цус цусан бүтээгдэхүүн хариуцсан мэргэжилтнээр түр томилсон байна. Тухайн ажилтан 2022 онд төрийн албаны тусгай шалгалт өгч жинхэлсэн байна.
- Эрүүл мэндийн газрын даргын Халдварт өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтний орон тооны ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагад хүний их эмч, нийгмийн эрүүл мэнд судлал, халдвар судлал гэж заасан байхад Эрүүл ахуйч, тархавар судлаач мэргэжилтэй хүн ажиллаж байна.

Төрийн байгууллагуудыг албан тушаалын тодорхойлолтыг боловсруулахад нь бодлого, арга зүйгээр хангаж ажиллахыг Төрийн албаны Увс аймаг дахь салбар зөвлөлд зөвлөмж болгов.

1.3.2. Төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгаагаар хангах хөтөлбөр төсөл, үйл ажиллагаа, урамшуулах систем нь төсөв хүрэлцээгүйгээс шалтгаалан бүрэн хэрэгжүүлж чадахгүй байна.

Нийгмийн баталгаа, сургалтын хөтөлбөрийг Төрийн албаны тухай хуулийн 55.3-д заасны дагуу байгууллага бүр гаргаж хэрэгжүүлэх ёстой. Төсөвт байгууллагууд хөтөлбөр гарган хэрэгжүүлж байгаа боловч хэт ерөнхий тусгадаг, мөн авч хэрэгжүүлж байгаа хөтөлбөр төсөл, үйл ажиллагаа, урамшуулах систем нь төсөв хүрэлцээгүйгээс шалтгаалан бүрэн хэрэгжихгүй байна.

Орон нутагт ажиллаж байгаа боловсролын салбарын багш, эрүүл мэндийн салбарын эмч, сувилагч, мэргэжилтэн 3 жил тутамд нэг удаа, Соёлын байгууллагын мэргэжлийн албан хаагчид болон Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан хаагчид, Цэргийн байгууллагын офицер, ахлагчид, төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутамд нэг удаа мөнгөн урамшуулал олгож байна.

Төрийн албан хаагчдын цалин хөлсийг үнийн өсөлттэй уялдуулан 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувь нэмэгдүүлсэн байна. Орон нутгийн нэмэгдлийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хөдөөгийн сумдад ажиллаж байгаа албан хаагчид үндсэн цалингийн 40 хувиар, аймгийн төвд ажиллаж байгаа төрийн албан хаагчдад үндсэн цалингийн 20 хувиар тооцон олгож эхэлжээ.

Архивын тасгийн албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан, Цаг уур, орчны шинжилгээний газар, Мал эмнэлгийн газар, Нийгмийн хамгааллын салбарын зарим албан хаагчдыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс ажлын онцлог, нөхцөлөөс хамааруулан төрийн нийтлэг үйлчилгээний албан тушаалаас төрийн мэргэжлийн үйлчилгээний албан тушаалд шилжүүлсэн зэрэг нь төрийн албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдсэн байна.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудын хувьд нийгмийн баталгааг дараах байдлаар ханган ажиллажээ. Үүнд:

- ✓ Удирдлагын академийн сургалтын нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд Увс аймагт ирсэн квотын дагуу төрийн албан хаагчдыг тогтмол сургаж байна.
- ✓ Наранбулаг сумын ЕБС нь математик, физик, биологийн багш нарыг, Өлгий сумын ЕБС нь дуу хөгжмийн багшийг тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд байр, хоолоор ханган ажиллаж байна.

- ✓ Улаангом сумын 11 дүгээр цэцэрлэг нь бүлгийн багш, туслах багш нарыг мэргэжил дээшлүүлэх болон магистрын сургалтад суралцах нөхцөл боломжоор ханган ажилласан байна.
- ✓ Түргэн сумын Эрүүл мэндийн төв нь бусад сум, аймгаас ирсэн эмч ажилтныг сумын Засаг даргатай зөвшилцөн орон байраар хангах, газар олгох зэргээр дэмжиж байна.
- ✓ Бусад байгууллагын хувьд дотоод журамд заасан түлээ нүүрсний хөнгөлөлт, рашаан сувилалд амруулах, хамт олныг идэвхжүүлэх ажлын хүрээнд спортын болон үндэсний хөгжөөнт тэмцээн зохион байгуулах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах арга хэмжээг хэрэгжүүлж байна.
- ✓ Боловсролын салбарт Элсэлтийн ерөнхий шалгалтаар өндөр оноо авсан сурагч, бэлтгэсэн багшийг, олимпиадад амжилт гаргасан багш, сурагчийг урамшуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

1.3.2.1. Цалингийн шатлалыг Эрүүл мэндийн газраас бусад байгууллага, зэрэг дэвийн нэмэгдлийг төсөвт байгууллагууд үндэслэлтэй олгож байна.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагууд цалингийн шатлалыг Засгийн газраас баталсан албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтын дагуу, зэрэг дэвийн нэмэгдлийг Монгол улсын Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу төрийн захиргааны албан хаагчдад, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын дагуу төрийн үйлчилгээний албан хаагчдад олгож байна.

Харин аймгийн Эрүүл мэндийн газарт дараах зөрчил байна. Үүнд:

- ✓ Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан ТҮЭМ салбарын цалингийн сүлжээгээр Эм эмнэлгийн хэрэгсэл хариуцсан нярвыг ТҮЭМ-4 шатлалаар 799.8 мянган төгрөгөөр цалинжихаар байхад 2023 онд бүтэц орон тоо, цалин шинэчлэн батлахдаа 999.8 мянган төгрөгөөр, 2024 онд 1,213.0 мянган төгрөгөөр цалинжихаар байхад 1,413.0 мянган төгрөгөөр цалинжуулж байжээ. Тухайн албан хаагч 2024 онд өндөр насны тэтгэвэрт гарсан байна.
- ✓ Эрүүл мэндийн салбар 2023, 2024 онд бүтэц орон тоо, цалинг шинэчлэн батлахдаа төрийн үйлчилгээний зарим албан хаагчдын цалинг Засгийн газрын тогтоолоор баталсан цалингийн доод хэмжээнээс 50.0-200.0 мянган төгрөг хүртэл харилцан адилгүй дүнгээр нэмэгдүүлэн тогтоосон байна. Уг асуудлыг холбогдох газраас нь тодруулахаар албан бичиг хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.3.2.2. Төрийн жинхэнэ албан хаагчид цалин, цол, зэрэг дэвийн нэмэгдлийг давхардуулан олгоогүй байна.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудын төрийн жинхэнэ албан хаагчид цалин, цол, зэрэг дэвийн нэмэгдлийг давхардуулан олгоогүй байна.

1.3.2.3. Төсөвт байгууллагууд орон нутгийн нэмэгдлийг 20-80 хувиар, бусад нэмэгдлийг хууль, тогтоомжийн хүрээнд олгож байна.

Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ыг баталсан бөгөөд Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсныг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж байна.

Журмын 2.1-д “Орон нутагт ажилласны нэмэгдлийг хөдөөгийн сум (тосгон)-д ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар, аймгийн төв болон нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар тус тус бодож, сар бүр олгоно”,

2.3-д "Орон нутагт ажилласны нэмэгдлийг тухайн орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид нэмж олгох асуудлыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвтөө тусган шийдвэрлэж болно" гэж заасан байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа улсын төсвийн байгууллагуудын хувьд зарим нь Засгийн газрын баталсан 20 хувийн нэмэгдэл авч байхад зарим нь аймгийн ИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 16/04 дүгээр тогтоолоор 10 хувь нэмж батлагдсанаар аймгийн төвд 30 хувь, хөдөө суманд 50 хувийн орон нутгийн нэмэгдэл авч байна.

Орон нутгийн төсөвт байгууллагуудын хувьд аймгийн ИТХ-ын болон сумдын ИТХ-ын шийдвэрийн дагуу нэмж баталснаар 40-80 хувийн орон нутгийн нэмэгдэл авч байна.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагууд бусад нэмэгдэл, хөнгөлөлтийн хувьд хууль, тогтоомжид заасан хувь хэмжээгээр батлагдсан төсвийн хүрээнд олгосон байна.

1.3.2.4. Төрийн байгууллагууд төрийн албан хаагчийг төсвөөс бус санхүүжүүлэн ажиллуулсан асуудал байхгүй байна.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудад төрийн албан хаагчийг төсвөөс гадуур санхүүжүүлэн ажиллуулаагүй байна.

1.3.2.5. Төрийн албан хаагчид нөхөх төлбөрийг төсөв санхүүжилтийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан холбогдох хууль, журмын дагуу олгож чадахгүй байна.

Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 06 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ыг баталсан байна.

Журмын 1.2-д "Төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр дараах төрөлтэй байна" гэж заажээ. Үүнд:

- 1.2.1. Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр;
- 1.2.2. Албан ажлын хэрэгцээнд хувийн автомашин хэрэглэсний нөхөх төлбөр;
- 1.2.3. Гадаад улс болон өөр орон нутагт ажиллахаар томилогдсон төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр;
- 1.2.4. Төрийн албан хаагчийн эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөх төлбөр;
- 1.2.5. Замын зардлыг нөхөх төлбөр;
- 1.2.6. Эмчилгээний зардлыг нөхөх төлбөр;
- 1.2.7. Бусад нөхөх төлбөр.

Журмын 1.3-д "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгоход шаардагдах хөрөнгийг тухайн байгууллага төсөвтөө тусгаж санхүүжүүлнэ" гэж заасан боловч тусгаж баталдаггүй, төсөв санхүүжилтийн хүрэлцээгүй байдгаас шалтгаалан журмын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал: Аудитын түүвэрт хамрагдсан төсөвт байгууллагуудад дараах асуудал байна. Үүнд:

- Эрүүл мэндийн газрын батлагдсан бүтэц орон тоогоор 51, одоо 45 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Гэтэл Сангийн яамнаас 40 орон тооны санхүүжилтийг баталсан байна. Ажилтнуудад зарим саруудад хоолны нэмэгдлийг санхүүжилт хүрэхгүй шалтгаанаар олгоогүй, мөн Хяналтын улсын байцаагч нарт албан томилолтоор ажиллахад томилолтын мөнгө олгохгүй байна.
- Журмын 8.4-д "Төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгоно" гэж заасны дагуу орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын батлагдсан төсвөөс хамааран зарим байгууллагад огт олгохгүй байхад зарим байгууллагад нэг өдрийн хоолны мөнгө 2500- 25000 төгрөг хүртэл ялгавартай олгож байна.

Бусад төрлийн нөхөх төлбөр байгууллагын төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан харилцан адилгүй олгож байна.

Цаашид Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох санхүүжилтийг төсөвт нь тусгаж батлах, бүс, орон нутгийн түвшинд жишиг, норм тогтоож өгөх шаардлагатай байна.

1.3.2.6. Төрийн албаны зардлыг бууруулах талаар төрөөс авах арга хэмжээний хүрээнд төрийн албан хаагчдад олгох цалин хөлс нэмэгдүүлэхийг болон нөхөх төлбөр, тусламжийг түр зогсоож байсан байна.

Төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталсан. Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно, 15.1.3 дахь заалтад “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэж тусгасан байна.

Мөн Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, **цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх**, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасан байна.

Дээрх хуулийн хүрээнд төрийн албан хаагчдад олгох цалин хөлс нэмэгдүүлэхийг болон нөхөх төлбөр, тусламжийг түр зогсоож байсан байна.

1.3.3. Төрийн байгууллагуудад гарсан сул орон тоог хууль болон холбогдох журмын дагуу олон нийтэд ил тод мэдээлж байгаа ч зарим байгууллага нөөцөд бүртгэгдсэн болон нээлтэй сонгон шалгаруулалтаар сонгогдсон албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан иргэдээс нөхөн томилоогүй байна.

1.3.3.1. Сул орон тоог олон нийтэд нээлттэй зарлан мэдээлж байна.

Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсэгт “Сул орон тоо” гэж төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, халсан, өөр албан тушаалд сонгогдсон, томилогдсон, эсхүл төрийн жинхэнэ албан хаагч нас барсны улмаас тухайн албан тушаалын орон тоо суларсан байхыг хэлнэ” гэж заажээ.

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-д “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо

хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ” гэж заасан байна.

Төрийн захиргааны албан тушаалтны хувьд сэлгэн, шилжих зарыг төрийн албан хаагчдын дунд журмын дагуу 5 өдөр нийтэд зарлаад материал ирүүлээгүй бол тусгай шалгалтыг нөөцөд байгаа хүмүүсийн дунд зарлахаар байна.

Бусад төрийн үйлчилгээний байгууллагын хувьд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт “Мэдээлэл хариуцагч өөрийн хүний нөөцийн талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана”, 8.3.1 дэх заалтад “ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл”, 8.3.2 дахь хэсэгт “албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам”, 8.10 дахь хэсэгт “Мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, ажлын байрны сул орон тоо, мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн талаарх зэрэг бусад мэдээллийг мэдээлэл хариуцагч тухай бүр нь цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд байршуулна” гэж заасан байна.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудын хувьд дээрх хууль тогтоомжийн хүрээнд сул орон тоог нийтэд нээлттэй зарлан мэдээлсэн байна.

1.3.3.2. Зарим байгууллагууд сул орон тооны нөөцөд бүртгэгдсэн, нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгогдсон болон албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан иргэдийг нөхөн томилоогүй байна.

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасныг зөрчсөн дараах асуудлыг Төрийн албаны Увс аймаг дахь салбар зөвлөлд шилжүүлсэн. Үүнд:

- ✓ Аймгийн ЗДТГ нь Төрийн албаны тусгай шалгалтад ороогүй 3, тухайн 3 ажилтны 1 нь төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцээгүй байхад төрийн захиргааны албан тушаалд томилж, нийт 24,232.2 мянган төгрөгийн цалин олгосон зөрчлийг ТАГ-ын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 116 дугаар албан бичгээр,
- ✓ Аймгийн Засаг дарга нь сонгон шалгаруулалт зарлуулахгүйгээр Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг томилж 25,585.4 мянган төгрөг, Орон нутгийн өмчийн газар нь төрийн албаны тусгай шалгалтад ороогүй иргэнийг худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтнээр томилж 7,354.0 мянган төгрөгийн цалин тус тус олгосон зөрчлийг ТАГ-ын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 118 дугаар албан бичгээр,
- ✓ Аймгийн Засаг дарга нь сонгон шалгаруулалт зарлуулахгүйгээр Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг томилж 21,299.3 мянган төгрөгийн цалин олгосон зөрчлийг ТАГ-ын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 114 дүгээр бичгээр тус тус хүргүүлсэн.

Авлигатай тэмцэх газрын Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянаж Авлигатай тэмцэх газрын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 05/13024 дүгээр албан бичгээр “Завхан сумын Засаг даргаар томилогдохоор нэр дэвшсэн А.Ягаан нь Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.2 дахь заалтад “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад нэр дэвшигч нь төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх” гэж заасан шаардлагыг хангаагүй байх тул хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ үү” гэсэн хариу ирүүлсний дагуу аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 1/1694 дүгээр бичгээр сумын ИТХ-ыг дахин хуралдуулж шаардлага хангасан хүнийг нэр дэвшүүлэх чиглэл өгч байжээ. Гэтэл аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн Б/94

дүгээр “Засаг дарга томилох Засаг дарга чөлөөлөх тухай” захирамжаар А.Ягааныг 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн Завхан сумын Засаг даргаар томилсон байна.

Улмаар Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, 64.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн “Шүүр ажиллагааны хэрэгжилтийг хангах тухай” ХЭГ/595 дугаар албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн Б/55 дугаар захирамжаар үүрэгт ажлаас нь чөлөөлж, аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн Б/22 дугаар захирамжаар дахин сумын Засаг даргаар томилсон байна.

Монгол Улсын Их хурлаас 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халснаас гадна хууль бусаар томилох, мөн төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой төрд учруулсан хохирлын асуудлыг Төрийн албаны зөвлөл хариуцаж, нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасны дагуу 2022 оны 07 дугаар сараас хойш А.Ягаанд олгосон цалин нийт 58,300.5 мянган төгрөгийн төрд учруулсан хохирлыг холбогдох этгээдээр төлүүлэх тухай албан бичгийг Төрийн албаны Увс аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлэхээр шийдвэрлэв.

Увс аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцон тэнцсэн иргэнийг томилуулах тухай ТА3-ийн 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 292 дугаар нэр дэвшүүлсэн тогтоолыг 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 02/1833 албан бичгээр аймгийн ИТХ-д ирүүлсэн ч одоог болтол хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөмж болгов.

Дараах ажлын байрнуудад түр орлон гүйцэтгэгчид ажиллаж байна.

- Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн Б/20 дугаар захирамжаар Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр дотоод аудитор Г.Алтанлхамыг томилон ажиллуулж байна.
- Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 17 дугаар хуралдаанаар Увс аймгийн төрийн захиргааны байгууллагуудын төрийн жинхэнэ албан хаагчдыг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж зөвлөн тусалсан ажлын хэсгийн тайланг хянан хэлэлцээд 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 172 дугаар тогтоол гаргаж хүргүүлсэн байна. Уг тогтоолын 3-д "Тогтоолын 1-5 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий иргэн албан хаагчийг албан тушаалд томилсон шийдвэрийг Захиргааны ерөнхий хуульд заасан шийдвэр гаргах ажиллагааны журамд нийцүүлэн 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүчингүй болгохыг томилох эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай" гэж заасан байна. Уг шийдвэрийн дагуу аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цогтсайханыг үүрэгт ажлаас нь чөлөөлөөгүй байсан. Харин Төрийн албаны салбар зөвлөлөөс Сонгон шалгаруулалтын захиалга өгсний дагуу сэлгэн шилжүүлэх зар нийтлэгдсэн байна. Уг асуудлыг Увс аймаг дахь Төрийн аудитын газраас аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар зөвлөмж өгсөнд аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/1170 дугаар бичгээр Худалдан авах ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цогтсайхан нь аймгийн сонгуулийн хорооны гишүүнээр томилогдон ажиллаж байгаа тул УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.19 дэх хэсэгт "Сонгуулийн хороодын ажилтныг энэ хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацаанд үндсэн ажлаас нь чөлөөлөх, огцруулах, түүнчлэн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно" гэж заасны дагуу УИХ-ийн сонгуулийн хорооны үйл ажиллагаа татан буугдсаны дараа сонгон шалгаруулалтын захиалгыг хүргүүлэх болно гэсэн хариуг ирүүлж байсан. Тухайн ажилтан өндөр насны тэтгэвэр гарсан байна.

- Өлгий сумын ЭМТ-ийн даргын орон тоонд сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Б/20 дугаар захирамжаар төрийн албаны тусгай болон, ерөнхий шалгалт өгөөгүй, хүүхдийн эмчээр ажиллаж байсан Б.Энхжинг түр орлон гүйцэтгэгчээр томилж одоог хүртэл түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна.
- Өмнөговь сумын ЕБС-ийн захирлын орон тоонд сумын Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн Б/10 дугаар захирамжаар төрийн албаны тусгай болон, ерөнхий шалгалт өгөөгүй, физикийн багшаар ажиллаж байсан Ш.Батчулууныг түр орлон гүйцэтгэгчээр томилж одоог хүртэл түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна.
- Өлгий сумын ЕБС-ийн захирлын орон тоонд Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн Б/39 дүгээр тушаалаар төрийн албаны тусгай болон ерөнхий шалгалт өгөөгүй, бага ангийн багш Д.Болор-Эрдэнийг түр орлон гүйцэтгэгчээр томилон ажиллуулж байна.
- Завхан сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн Б/04 дүгээр захирамжаар төрийн албаны ерөнхий болон сонгон шалгаруулалтад ороогүй, эм зүйч мэргэжилтэй Ц.Бадамхандыг ЭМТ-ийн даргын албан тушаалд түр томилсон байна. Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 1/816 дугаар захирамжаар ЭМТ-ийн даргын албан тушаалд Ц.Бадамхандыг томилсон захирамж нь холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн тул уг захирамжийг хүчингүй болгох чиглэл хүрүүлснээр 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Б/05 дугаар захирамжаар ажлаас чөлөөлсөн ч, 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн Б/13 дугаар захирамжаар дахин томилсон байна.
- Өмнөговь сумын ЭМТ-ийн даргын орон тоонд сумын Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн Б/28 дугаар захирамжаар төрийн албаны тусгай болон, ерөнхий шалгалт өгөөгүй, эм зүйчээр ажиллаж байсан Б.Бадамгаравыг түр орлон гүйцэтгэгчээр томилж одоог хүртэл түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна.
- Сагил сумын ЭМТ-ийн даргын орон тоонд сумын Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн Б/09 дүгээр захирамжаар төрийн албаны тусгай болон ерөнхий шалгалт өгөөгүй Ц.Соёлмааг түр орлон гүйцэтгэгчээр томилж одоог хүртэл түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна.
- Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн Б/294 дүгээр тушаалаар Насан туршийн суралцахуйн төвийн захирлын үүргийг хавсран гүйцэтгэгчээр тус төвийн менежер Т.Тогтохбаярыг захирлын сонгон шалгаруулалт зохион байгуулагдан томилогдох хүртэл хугацаанд томилсон байна. Тухайн ажлын байрны албан тушаалын тодорхойлолт нь батлагдаж ирээгүйгээс сонгон шалгаруулалт зарлагдаагүй гэх шалтгаанаар одоог хүртэл ажиллаж байна.
- Улаангом сумын ЗДТГ-ын Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байранд тусгай шалгалт өгч тэнцсэн Л.Төгсжаргалыг 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Б/23 дугаар тушаалаар томилж, 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн Б/92 дугаар тушаалаар Худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан мэргэжилтнээр сэлгэн, шилжүүлэн ажиллуулсан байна. Тухайн шилжин ажилласан ажлын байранд сонгон шалгаруулалт зарлагдаагүй байх бөгөөд Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байранд төрийн албаны тусгай шалгалт өгөөгүй Э.Гончигийг 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн Б/93 дугаар тушаалаар түр орлон гүйцэтгэгчээр, Б.Бурмааг 2023 оны 10 дугаар сарын 02-ны Б/79 дүгээр тушаалаар түр орлон гүйцэтгэгчээр томилон ажиллуулж байжээ.

Цаашид сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжийн хүрээнд явуулж байхыг зөвлөмж болгов.

Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3 дахь заалтад “энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх”, 43.3.4 дэх заалтад “жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, түүнчлэн эрүүл мэндийн шалтгааны улмаас 3 сараас 1 жил хүртэл хугацаагаар эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон тохиолдолд албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай албан хаагчаар, эсхүл төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч, тодорхой хугацаагаар түр орлон гүйцэтгүүлэх” гэж заасныг дараах байгууллагууд зөрчсөн байна. Үүнд:

- Завхан сумын ИТХ-ын мэргэжилтний жирэмсний амралттай байх хугацаанд Төрийн албаны ерөнхий шалгалт өгөөгүй иргэнийг ИТХ-ын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон

гүйцэтгэгчийн 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Б/04 дүгээр тушаалаар түр томилж 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл ажиллуулж 2,457.4 мянган төгрөг олгосон байна. Томилгоотой холбоотойгоор төрд учруулсан хохирлыг холбогдох этгээдээр төлүүлэх тухай албан бичгийг Төрийн албаны Увс аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлэхээр шийдвэрлэв.

- Эрүүл мэндийн газрын Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагчийн орон тоонд ажиллаж байсан З.Баялаг хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд тухайн ажлын байранд Б.Цэнгэлийг түр орлон гүйцэтгэгчээр томилж, З.Баялаг ажилдаа буцаан ороход урд эрхэлж байсан ажил албан тушаалд нь эргүүлэн авах гэж тушаал гаргасан боловч халдвар хяналт хариуцсан байцаагчаар ажиллуулж байна. Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчийн нэг орон тоонд сонгон шалгаруулалт зарлахгүйгээр жирэмсэн амаржсан хүний оронд түр томилогдсон ажилтан тухайн ажлын байрны үндсэн ажилтан ажилдаа буцаж орсон ч үргэлжлүүлэн ажилласаар байна. Мөн тухайн ажилтан байцаагчийн эрхгүй байх бөгөөд, албан тушаалын тодорхойлолтод мэргэжил таарахгүй байна. Тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөмж болгов.

Төрийн албаны Увс аймаг дахь салбар зөвлөлөөс Хуурамч диплом ашигласан, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан хориглох зүйлсийг зөрчиж, албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан гэмт хэргийн шинжтэй асуудлыг шалгуулахаар холбогдох байгууллагад шилжүүлсэн нь дараах байдлаар шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 8.

Д/д	Албан бичгийн огноо дугаар	Гомдол мэдээллийн утга	Шилжүүлсэн байгууллага	Шийдвэрлэсэн байдал
1	2024.04.23 №48	Түргэн сумын ойн ангийн дарга М.Дээшин хамаарал бүхий этгээдээ томилж албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласан.	Авлигатай тэмцэх газар	Зөрчлийг арилгуулж шийдвэрлэсэн
2	2024.04.23 №49	Завхан сумын Засаг даргын орлогч М.Цовоохүү бусдад давуу байдал олгосон.	Авлигатай тэмцэх газар	Зөрчлийг арилгуулж шийдвэрлэсэн
3	2024.03.04 №36	Ойрад театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Баярмагнай хуурамч диплом ашигласан.	Увс аймгийн Цагдаагийн газар	Прокурор хэргийг хаасан.
4	2024.01.31 №24	Түргэн сумын Соёлын төвийн дарга Д.Алтанцэцэг хамаарал бүхий этгээдээ томилж албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласан.	Авлигатай тэмцэх газар	Шалгагдаж байна.
5	2023.06.19 №107	Өмнөговь сумын Соёлын төвийн дарга Ө.Ундармаа хамаарал бүхий этгээдээ томилж албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласан.	Авлигатай тэмцэх газар	Зөрчлийг арилгуулж шийдвэрлэсэн

Эх сурвалж: / Увс аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөл /

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудад дараах зөрчил илэрсэн: Үүнд:

- ✓ Завхан сумын Соёлын төвийн бүжгийн багшийн орон тоонд ажлын байрны тусгай шаардлагад нийцээгүй хөдөлмөрийн эдийн засагч мэргэжилтэй Л.Норовсүрэнг 2021 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн Б/04 дүгээр тушаалаар түр томилсон байна.
- ✓ Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын Урлаг, уран бүтээлийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байранд тавигдах тусгай шаардлагад тусгасан мэргэжилд урлаг, соёл судлал, багш, урлагийн боловсрол, менежмент, соёл, урлагийн, уран зохиол, хэл шинжлэл гэж заасан байхад Номын сан-мэдээллийн ажилтны мэргэжилтэй Н.Соёлмааг 2022 оны 03

- дугаар сарын 17-ны өдрийн Б/10 дугаар тушаалаар ажилд түр томилсон байна. Тухайн ажилтан жирэмсэн амаржсаны чөлөө авсан тул тухайн ажлын байранд сонгон шалгаруулалт зарлах боломжгүй болж, тухайн ажлын байрны сул орон тоонд нөөцөд бүртгэгдсэн хүнийг түр тушаалаар ажиллуулж байна.
- ✓ Чандмань Увс ХХК-ийн борлуулалт маркетингийн менежерийн ажлын байрны тодорхойлолтын 6-д ажлын байранд тавигдах шаардлагад Санхүү, эдийн засгийн дээд боловсролтой байхаар заасан байхад Мал эмнэлгийн эм зүйч мэргэжилтэй Д.Ундармааг 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/02 дугаар тушаалаар түр, 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн Б/45 дугаар тушаалаар үндсэн ажилтнаар томилон, 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/18 дугаар цалин хөлс нэмэгдүүлэх тухай тушаалын хавсралтад аж ахуйн борлуулалтын байцаагч болгон өөрчлөлт оруулж, эдийн засагчийн орон тоог эдийн засагч борлуулалтын менежер болгон ажиллуулсан байна. Аж ахуйн борлуулалтын байцаагчийн ажлын байрны тодорхойлолт байхгүй байна.
 - ✓ Аймгийн ЗДТГ-ын нягтлан бодогчоор 2024 оны 05 дугаар сарын 03-ны Б/38 дугаар тушаалаар Д.Болортуяаг түр томилсон байна. Тухайн ажлын байранд тавигдах тусгай шаардлагад нягтлан бодогч мэргэжилтэй байхаар заасан байхад Д.Болортуяа нь 2020 онд Нэхмэл үйлдвэрлэлийн технологи мэргэжлээр бакалавр төгссөн, 2021 онд 04110101 индекстэй Нягтлан бодох бүртгэл мэргэжлээр магистрын зэрэг хамгаалсан байна. Тухайн ажилтан 2024 оны 10 сард ажлаас гарсан байна.
 - ✓ Аймгийн ЗДТГ-ын даргын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн Б/44 дүгээр тушаалаар А.Ариунтуяаг дотоод ажил, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтнийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон байна. А.Ариунтуяа нь хөрс хамгаалал усжуулалтын инженер мэргэжилтэй байх бөгөөд тухайн ажлын байрны албан тушаалын тодорхойлолтод тавигдах тусгай шаардлагын мэргэжилд таарахгүй байна. Тухайн ажилтан 2024 оны 10 сард ажлаас гарсан байна.
 - ✓ Аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн Б/42 дугаар тушаалаар М.Болормааг Тоног төхөөрөмжийн ашиглалт, дотоод сүлжээ хариуцсан ажилтнаар томилсон байна. М.Болормаа нь нийгмийн ажилтан мэргэжилтэй байх бөгөөд тухайн ажлын байрны албан тушаалын тодорхойлолтод тавигдах тусгай шаардлагын мэргэжилд таарахгүй байна. Тухайн ажилтан 2024 оны 10 сард ажлаас гарсан байна.
 - ✓ Өмнөговь сумын ЗДТГ-ын мэдээлэл технологи, лавлагаа мэдээлэл хариуцсан ажилтны ажлын байрны тодорхойлолтын тусгай шаардлагад мэргэжил - мэдээлэл технологийн инженер, мэдээлэл зүйн багш IT инженер гэсэн байхад Нягтлан бодох бүртгэлийн үндэс, санхүүгийн бүртгэлийн курсийн гэрчилгээ, Иргэний боловсрол улс төрийн их сургуулийн Улс төрийн дээд боловсролын дипломтой хүн түр тушаалаар ажиллаж байна.

Төсөвт байгууллагуудын сул орон тоонд албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан иргэдийг томилж байх зөвлөмж, чиглэлийг төрийн байгууллагуудад хүргүүлж ажиллахыг эрх бүхий албан тушаалтанд зөвлөмж болгов.

1.3.3.3.Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар нь Төрийн үйлчилгээний ангилал зэрэглэлээр батлагдсан орон тоог төрийн жинхэнэ албаны ангилалд хамааруулан томилон ажиллуулсан байна.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/40 дүгээр тушаалын 18 дугаар хавсралтаар Увс аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын бүтэц, орон тоонд Төрийн үйлчилгээний ангилал зэрэглэлээр батлагдсан Баруун бүсийн ахмадын асуудал хариуцсан албан тушаалд Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн Б/44 дүгээр тушаалаар Ж.Энхтүвшинг ТЗ-5 ангиллын 3 дугаар шатлалаар 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл ажиллуулжээ. Уг албан хаагчийг 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Б/11 дүгээр тушаалаар нийгмийн халамжийн хэлтсийн халамжийн сангийн олголт хариуцсан мэргэжилтний албан тушаалд шилжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 312 дугаар тогтоолыг үндэслэн Орон нутгийн хөгжлийн сан хариуцсан ажилтны ажлын байрны тодорхойлолтыг төрийн үйлчилгээний ангилал зэрэглэлээр батлан Засаг даргын тамгын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Б/29 дүгээр тушаалаар Б.Гомбосүрэнг томилсон байна. Уг албан

тушаалыг аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/701 захирамжаар төрийн захиргааны албан тушаал болгон шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 376 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн ИТХ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/01 дүгээр захирамжаар бүтэц, орон тоог шинэчлэн 2 хэлтэс 12 орон тоогоор батлахдаа эдийн засаг, санхүү хариуцсан мэргэжилтэн ТЗ-5 байхаар төрийн захиргааны орон тоо тусгасан боловч сонгон шалгаруулалтыг зарлаагүй, өмнө нь нягтлан бодогчоор ажиллаж байсан ажилтныг тухайн ажлын байранд төрийн үйлчилгээний ангилал зэрэглэлээр цалинжуулж ажилласан байна. Улмаар 2024 онд тухайн орон тоог буцаан нягтлан бодогчийн орон тоо болгож баталсан байна.

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/01 дүгээр "Бүтэц орон тоо, цалин шинэчлэн тогтоох тухай" тушаалаар Хэлтсийн дарга-Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт, мэргэжлийн зөвшөөрөл, хариуцсан-ТЗ-6 зэрэглэлд ажиллаж байсан Б.Буяаг 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Б/01 дүгээр "Бүтэц орон тоо, цалин шинэчлэн тогтоох тухай" тушаалаар Хэлтсийн дарга-мэргэжлийн зөвшөөрөл, хариуцсан мэргэжилтнээр ТЗ-6 зэрэглэлээр, мөн албан тушаал өөрчилж томилсон тушаал шийдвэргүйгээр 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Б/16 дугаар "Эрүүл мэндийн газрын албан хаагчдын цалин шинэчлэн тогтоох тухай" тушаалаар Хүний нөөцийн хангалт, сургалт хариуцсан менежерээр ТҮЭМ-7 зэрэглэлд ажиллуулсан байна. Энэ нь Хэлтсийн дарга-Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт, мэргэжлийн зөвшөөрөл, хариуцсан-ТЗ-6 зэрэглэлийн 1 орон тооны ажлыг 2 орон тоо болгон салгаж шилжүүлэн томилсон байна. Албан тушаалтныг өөр ажил албан тушаалд шилжүүлэн томилохдоо тушаал шийдвэр гаргаж байхыг зөвлөв.

Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолын 2-р хавсралтаар "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт"-ыг баталж, Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан байна. Уг жагсаалтад ТҮЭМ-7 зэрэглэлд хамаарах 4 албан тушаалд Эрүүл мэндийн газрын Хүний нөөцийн хангалт, сургалт хариуцсан менежер гэсэн албан тушаал байхгүй байна. Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт"-д аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын мэргэжилтний ажлын байр нь ТЗ-9 зэрэглэлээр цалинжихаар заасан, мөн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллага боловч зарим албан тушаалын тодорхойлолт батлахдаа Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолыг жишиг болгон баталсан байна. Жишээ нь: Эрүүл мэндийн газрын жолоочийг ТҮЭМ-2 буюу түргэн тусламжийн жолоочийн ангилал зэрэглэлээр цалинжуулж байна. Цаашид Засгийн газрын баталсан албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг мөрдөж ажиллахыг зөвлөмж болгов.

1.3.3.4. Төрийн албаны тухай хуульд заасан стандартыг батлан мөрдүүлж байна.

Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлд "Төрийн албаны стандарт"-ыг тусгасан байна. Үүнд:

- ❖ 8.1.Төрийн албаны стандарт нь төрийн албыг үр дүнтэй удирдах, төрийн байгууллага, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахад чиглэнэ,
- ❖ 8.2.Төрийн албаны стандарт нь төрийн байгууллага чиг үүргээ, төрийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн менежментийн үйл ажиллагаанд тавих шаардлагыг тогтооно,
- ❖ 8.3.Төрийн албаны стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын

үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу боловсруулан баталж, мөрдүүлнэ гэж заажээ.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудын хувьд Төрийн албаны тухай хуульд заасан стандартын хэрэгжилт хэвийн байна.

1.3.3.5. Мерит зарчмын дагуу шатлан дэвших шаардлага, шалгуур нь байгууллагын түвшинд тодорхойгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад "Чадахуйн зарчим /мерит/" гэж иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлахыг" гэж заасан байна.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудад Мерит зарчмын дагуу шатлан дэвших шаардлага, шалгуур нь тодорхойгүй байна.

1.3.3.6. Шатлан дэвших тогтолцоо хэрэгжиж байна.

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий этгээд доор дурдсан журмын дагуу уг орон тоог нөхнө", 27.1.1 дэх хэсэгт "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд шатлан дэвших зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас болон энэ хуулийн 16.1-д заасан удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс", 27.1.2.төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас болон холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас" гэж заасан байна.

Төрийн албаны зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөлөөс төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас болон холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдад мэдэгдэж сонгон шалгаруулах журмаар шатлан дэвшүүлэх тогтолцоог хэрэгжүүлдэг байна.

Тухайлбал: Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Р.Дэлгэрмаа Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргаар, Б.Ганбат Нийгмийн бодлогын хэлтсийн даргаар дэс түшмэлийн ангиллаас ахлах түшмэлийн ангилалд шатлан дэвшсэн байна.

1.3.3.7. Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан шийтгэлтэй байх хугацаанд нь иргэнийг шатлан дэвшүүлсэн асуудал гараагүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7 дахь хэсэгт "Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно", Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсэгт "Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн өдрөөс хойш нэг жилийн дотор ёс зүйн зөрчил гаргаагүй бол түүнийг ёс зүйн шийтгэлгүйд тооцно" гэж заасан байна.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудад Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан шийтгэлтэй байх хугацаанд нь иргэнийг шатлан дэвшүүлсэн асуудал гараагүй байна.

1.3.4. Төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, төрд хохирол учруулсан байна.

1.3.4.1. Төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж хууль бусаар томилогдож, чөлөөлөгдсөн байна.

2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх хэсэгт “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ”, 103.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэж заасан байдаг.

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас төсөв захирагчдын жил бүрийн санхүүгийн тайланд аудит хийхдээ хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь тогтоогдож шүүхийн шийдвэрийн дагуу олгосон нөхөн олговрын зөрчлийг холбогдох нотлох баримтын хамт аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд шилжүүлсэн. Үүнд:

- ✓ 2016-2021 оны хооронд нийт 28 байгууллагын 34 ажилтанд олгосон 178,799.7 мянган төгрөгийн нөхөн олговор,
- ✓ 2022 онд 1 хүнд олгосон 7,260.0 мянган төгрөгийн нөхөн олговор,
- ✓ 2023 онд 9 хүнд олгосон 97,027.8 мянган төгрөгийн нөхөн олговор.

Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт “Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ”, 50.2 дахь хэсэгт “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана” гэж заасны дагуу хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь тогтоогдож шүүхийн шийдвэрийн дагуу олгосон нөхөн олговрын зөрчлийг холбогдох нотлох баримтын хамт Увс аймаг дахь Төрийн аудитын газраас Төрийн албаны Увс аймаг дахь салбар зөвлөлд шилжүүлсэн. Үүнд:

- ✓ 2023 онд 7 байгууллагын 9 ажилтны нийгмийн даатгалын шимгэлд 10,209.1 мянган төгрөг, ажилгүй байсан хугацааны цалинд 86,818.7 мянган төгрөг, нийт 97,027.8 мянган төгрөгийн нөхөн олговор,
- ✓ 2024 онд 4 байгууллагын 9 ажилтны нийгмийн даатгалын шимгэлд 9,246.9 мянган төгрөг, ажилгүй байсан хугацааны цалинд 94,766.6 мянган төгрөг, нийт 104,193.5 мянган төгрөгийн нөхөн олговор.

Аудитын явцад түүвэрт хамрагдсан байгууллагуудад хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь тогтоогдож, шүүхийн шийдвэрийн дагуу төрөөс нөхөх олговор олгосон дараах зөрчил байна.

- Завхан сумын ЕБС-ийн захирлын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн Б/36 дугаар тушаалаар слесар Д.Содбаярыг ажлаас чөлөөлсөн байна. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 152/ШШ2023/00338 дугаар шийдвэрийн дагуу ЕБС-ийн захирлын 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн Б/56 дугаар тушаалаар буцаан томилж, Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 152/ШШ2023/00472 дугаар захирамжийн дагуу Сургуулийн захирлын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Б/72 дугаар тушаалаар сахиул Д.Содбаярт ажилгүй байсан хугацааны цалин гэж 2,309.6 мянган төгрөг олгосон байна.
- Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Б/26 дугаар тушаалаар Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн Д.Отгоныг ажлаас чөлөөлсөн байна. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 04-

ний өдрийн 124/ШШ2024/0008 дугаар захирамжийг үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн Б/42 дугаар тушаалаар буцаан томилж, Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 152/ШШ2024/00284 дүгээр захирамжийн дагуу 2,159.5 мянган төгрөгийг олгосон байна.

Дээрх хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нь тогтоогдож, шүүхийн шийдвэрээр нөхөн олговор олгож төрд учруулсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэх асуудлыг Төрийн албаны Увс аймаг дахь салбар зөвлөлд албан бичгээр хүргүүлэхээр шийдвэрлэв.

Өмнөговь сумын Соёлын төвийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн Б/01 дүгээр тушаалаар бүжгийн багш Ч.Цэндсүрэнг ажлаас чөлөөлж, 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн Б/02 дугаар тушаалаар ажилд нь буцаан томилжээ. Сум дундын анхан шатны шүүхийн 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 152/ШШ2024/00344 дүгээр "... ажилгүй байсан хугацааны цалин 2,213.1 мянган төгрөгийн нөхөн олговор олгох" шийдвэр гарчээ. Аудитын явцад тухайн шүүхийн шийдвэр хэрэгжээгүй байсан тул дараагийн аудитаар үзэхээр шийдвэрлэв.

1.3.4.2. Төрийн албан хаагчийн эрх зөрчигдсөн маргаан нь хууль, журмын дагуу шийдвэрлэгдэж байна.

Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт "Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 66.1.3 дахь заалтад "Иргэн, байгууллага, албан хаагчийн гомдол, мэдээллийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай шаардлага хүргүүлэх, хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох" гэж заасны дагуу Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зөрчигдсөн маргааныг шалгаж тогтоол гаргаж байна. Мөн хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэгт "Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана" гэж заажээ.

Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлд "Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхахыг хориглох", 6.6 дахь хэсэгт "Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхагдсан гэж үзсэн хүн, ажилтан, ажилтны төлөөлөгч гомдлоо тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, дээд шатных нь албан тушаалтан, холбогдох төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллага, хууль хяналтын байгууллага, хөдөлмөрийн хяналтын байгууллага, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүхэд тус тус гаргаж болно. Гомдлыг хүлээн авах байгууллага, албан тушаалтны нэр, хаяг, харилцах утас, цахим шуудангийн хаягийг ажил олгогч нийт ажилтанд харагдахуйц газар байршуулах үүрэгтэй" гэж заасан байна.

Төрийн албан хаагчийн эрх зөрчигдсөн асуудал нь эцсийн шатанд Шүүхээр шийдвэрлэгдэж байна.

1.3.4.3. Хууль бус шийдвэрээс шалтгаалан төрд учруулсан хохирлын хэмжээг тогтоож байна.

Хууль бус шийдвэрээс шалтгаалан төрд учруулсан хохирлын хэмжээг орон нутгийн түвшинд Төрийн аудитын байгууллага, Төрийн албаны Увс аймаг дахь салбар зөвлөлөөс хийсэн хяналт шалгалтаар тогтоож байна.

1.3.4.4. Төрд учруулсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх асуудал хууль хяналтын байгууллагаар дамжиж удаашрах, зарим хууль тогтоомжийн уялдаагүй байдлаас шалтгаалан хангагдахгүй байх асуудал үүсэж байна.

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд шилжүүлсэн хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нь тогтоогдож, шүүхийн шийдвэрээр ажилд нь эргүүлж томилохоор тогтоосон 28 байгууллагын 34 ажилтанд олгосон 178,799.7 мянган төгрөгийн нөхөн олговроос 3,838.0 мянган төгрөгийг барагдуулж, үлдэгдэл 174,961.7 мянган төгрөгийн зөрчлийн шийдвэрлэлт дараах байдалтай байна. Үүнд:

- Шүүх байгууллага нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан 2 албан тушаалтны 11,929.0 мянган төгрөг,
- Шүүхийн шийдвэрээр нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөн 2 албан тушаалтны 6,544.8 мянган төгрөг,
- Сангийн сайдын албан бичгийн дагуу хүчингүй болсон 3 албан тушаалтны 6,714.9 мянган төгрөг,
- Ховд аймгийн шүүхийн шийдвэрээр хэргийг хүлээн авахаас татгалзсан 6 албан тушаалтны 39,138.1 мянган төгрөг,
- Шүүхийн шийдвэрээр төлөгдөхөөр тогтоосон боловч барагдуулаагүй байгаа 1 албан тушаалтны 2,430.9 мянган төгрөг,
- Прокурорын байгууллагад шилжүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй 20 албан тушаалтны 108,203.9 мянган төгрөгийн зөрчил байна.

Төрд учирсан хохирлын асуудлын шийдвэрлэлт хангалтгүй байгаа нь зарим хууль тогтоомжийн тодорхойгүй зүйл заалт, харилцан уялдаа муутай байдлаас шалтгаалж байна. Үүнд:

- Захиргааны ерөнхий хуулийн 82 дугаар зүйлд заасан гомдол гаргах хугацаа өнгөрсөн актад тус хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1.1-84.1.3 дахь хэсгүүдэд заасан Захиргааны шийдвэр гүйцэтгэх байгууллага актын биелэлтийг гүйцэтгэх боломжтой байна гэсэн үндэслэлээр хуулийн байгууллагад шилжүүлсэн асуудлыг буцаадаг. Захиргааны ерөнхий хуулийн 84-91 дүгээр зүйлд акт гаргасан захиргааны байгууллага шийдвэрээ албадан гүйцэтгэх, бусдаар гүйцэтгүүлэх зэргээр хэрэгжүүлэх эрхтэй байна” гэж заасан боловч албадлагыг хэрхэн хэрэгжүүлэх, ямар байгууллагаар гүйцэтгүүлэх талаар хуулийн зохицуулалт байхгүй байна.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна”, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 6.2.6-д зааснаас бусад тохиолдолд гүйцэтгэх баримт бичиггүйгээр иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахыг хориглоно” гэж тус тус заасан үндэслэлээр гүйцэтгэх баримт бичиггүйгээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах боломжгүй хуулийн зохицуулалттай байна.

Дээрх хуулиудын тодорхой бус зохицуулалтаас шалтгаалан Төрийн аудитын газраас Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд 2022, 2023 онд хүргүүлсэн төрд учирсан хохирол нөхөн төлүүлэх зөрчилд ямар нэг ажиллагаа явуулаагүй байна. Үүнд:

- 2022 он шилжүүлсэн хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нь тогтоогдож, шүүхийн шийдвэрээр ажилд нь эргүүлж томилохоор тогтоосон 1 хүнд олгосон 7,260.0 мянган төгрөгийн зөрчилд,
- 2023 онд шилжүүлсэн хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нь тогтоогдож, шүүхийн шийдвэрээр ажилд нь эргүүлж томилохоор тогтоосон 9 хүнд олгосон 97,027.8 мянган төгрөгийн зөрчилд,

Төрийн албаны Увс аймаг дахь салбар зөвлөлд төрийн албан хаагчийг хууль бусаар томилсноор төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр 2023 онд 7 байгууллагын 9 ажилтны нийгмийн даатгалын шимтгэлд 10,209.1 мянга, ажилгүй байсан хугацааны цалинд 86,818.7 мянга, нийт 97,027.8 мянган төгрөгийн зөрчлийг, 2024 онд 4 байгууллагын 9 ажилтны нийгмийн даатгалын шимтгэлд 9,247.0 мянга, ажилгүй байсан хугацааны цалинд 94,766.5 мянга, нийт 104,193.5 мянган төгрөгийн зөрчлийг шилжүүлсэн байна.

Төрийн албан хаагчийг хууль бусаар чөлөөлж, халснаар төрд учруулсан хохирлыг
нөхөн төлүүлэхээр Төрийн албаны зөвлөлд уламжилсан зөрчлийн
хэрэгжилтийн судалгаа

Хүснэгт 9.

Д/д	Албан тушаал	Албан хаагчийн нэр	Нэхэмжилсэн мөнгөн дүн	Хариуцагч албан тушаалтны нэр	Хэрэгжилт
1	Ойрад хөгжимт жүжгийн театрын дарга	Б.Лхагвасүрэн	23,263,186	Аймгийн Засаг дарга Ч.Чимэд	Шүүхийн шатанд хянагдаж байгаа
2	Музейн дарга	Ш.Цэдэнбал	11,000,000	Аймгийн Засаг дарга Ч.Чимэд	Шүүхийн шатанд хянагдаж байгаа
3	Биеийн тамир, спортын газрын дарга	Б.Ганболд	23,563,762	Аймгийн Засаг дарга Ч.Чимэд	Шүүхийн шатанд хянагдаж байгаа
4	Улаангом политехник коллежийн багш	Б.Хадбаатар	5,426,400	Улаангом политехник коллежийн захирал Б.Баттогтох	Хадбаатараар нөхөн төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсан
5	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даамал	М.Баттөгс	6,276,452	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Г.Отгонболд	Шүүхийн шийдвэр гарч хохирлыг барагдуулж байгаа
6	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын үйлчлэгч	Ч.Тунгалаг	4,797,297	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Г.Отгонболд	Шүүхийн шийдвэр гарч хохирлыг барагдуулж байгаа
7	Нэгдсэн эмнэлгийн дарга	Д.Доржготов	26,686,610	Аймгийн Засаг дарга Ч.Чимэд	Шүүх хүлээн аваагүй
8	Өндөрхангай сумын Соёлын төвийн номын санч	Л.Нямханд	5,448,005	Соёлын төвийн эрхлэгч А.Мөнхтуяа	Шүүхийн шатанд хянагдаж байгаа
9	Завхан сумын ИТХ- ын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	С.Энхцацрал	4,289,200	Завхан сумын ИТХ-ын дарга Цэвээн	Цэвээнээр нөхөн төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсан
10	Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн дарга	Б.Алтан	16,009,808	Аймгийн ЗДТГ- ын дарга Г.Болор-Эрдэнэ	Шүүхийн шатанд хянагдаж байгаа
11	Аймгийн ЗДТГ-ын нийтлэг үйлчилгээний албаны дарга	Б.Чимэддорж	7,259,572	Аймгийн ЗДТГ- ын дарга Г.Болор-Эрдэнэ	Шүүхийн шатанд хянагдаж байгаа
12	Аймгийн ЗДТГ-ын	Ш.Батмөнх	5,500,000	Аймгийн ЗДТГ-	Давж заалдах

	жолооч			ын дарга Г.Болор-Эрдэнэ	шатны шүүхийн шийдвэрээр нэхэмжлэлийг хүчингүй болгосон
--	--------	--	--	----------------------------	---

Эх сурвалж: / Увс аймаг дахь Төрийн аудитын газар /

Төрийн албаны зөвлөлөөс холбогдох этгээд нь мэдэгдэл хүргүүлж, тогтоосон хугацаанд төлж барагдуулаагүй бол Шүүхийн байгууллагад шилжүүлэх арга хэмжээг авч байна.

Төрийн албан хаагчийг хууль бусаар томилсноор төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр Төрийн албаны зөвлөлд уламжилсан зөрчлийн судалгаа

Хүснэгт 10.

Д/д	Албан тушаал	Албан хаагчийн нэр	Нэхэмжилсэн мөнгөн дүн	Хариуцагч албан тушаалтны нэр
1	Аймгийн ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Г.Болор-Эрдэнэ	64,670,323	Аймгийн Засаг дарга Ч.Чимэд
2	Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Ё.Мөнхзул	17,131,009	Аймгийн Засаг дарга Ч.Чимэд
3	Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Ц.Алимаа	55,215,776	Аймгийн Засаг дарга Ч.Чимэд
4	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Г.Отгонболд	17,057,251	Аймгийн Засаг дарга Ч.Чимэд
5	Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	С.Цолмон	26,906,685	Аймгийн Засаг дарга Ч.Чимэд
6	Биеийн тамир, спортын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Б.Пүрэвгончиг	47,750,645	Аймгийн Засаг дарга Ч.Чимэд
7	Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Н.Батбаяр	20,867,215	Аймгийн Засаг дарга Ч.Чимэд
8	Хууль, эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Ц.Загиржав	45,373,516	Аймгийн ЗДТГ-ын дарга Г.Болор-Эрдэнэ
9	Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Н.Цогт-Очир	52,462,078	Аймгийн ЗДТГ-ын дарга Г.Болор-Эрдэнэ
10	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Ж.Эрдэнэтогтох	14,452,727	Аймгийн ЗДТГ-ын дарга Г.Болор-Эрдэнэ
11	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн эрх ашгийг хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч	Ц.Гэрэлцэцэг	29,445,237	Аймгийн ЗДТГ-ын дарга Г.Болор-Эрдэнэ

Эх сурвалж: / Увс аймаг дахь Төрийн аудитын газар /

Дээрх зөрчилд холбогдуулан Төрийн албаны зөвлөлөөс 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 04/214 дүгээр “Төрд учруулсан хохирлыг нөхөн төлөх мэдэгдэл хүргүүлэх тухай” албан бичгээр 7 иргэнийг Төрийн албан хууль тогтоомж

зөрчин томилсонтой холбоотойгоор төрд учирсан хохирлын нийт 249,598.9 мянган төгрөгийг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор төлөх, хохирлыг нөхөн төлөөгүй тохиолдолд шүүхийн байгууллагад хандаж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргаар ажиллаж байсан Ч.Чимэдэд мэдэгдсэн байна.

Мөн судалгаанд тусгагдсан зөрчилд холбогдуулан Төрийн албаны зөвлөлөөс 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 04/215 дугаар “Төрд учруулсан хохирлыг нөхөн төлөх мэдэгдэл хүргүүлэх тухай” албан бичгээр 4 иргэнийг Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчин томилсонтой холбоотойгоор төрд учруулсан хохирол нийт 131,833.6 мянган төгрөгийг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор төлөх, хохирлыг нөхөн төлөөгүй тохиолдолд шүүхийн байгууллагад хандаж шийдвэрлүүлэхийг аймгийн ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан Г.Болор-Эрдэнэд мэдэгдсэн байна.

Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн мэдэгдлийг холбогдох этгээд нь төлж барагдуулаагүй учир Шүүхийн байгууллагад шилжүүлсэн байх бөгөөд шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй байна.

1.3.5. Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийн санг бүрэн бүрдүүлж, үр дүнтэй ашиглаж байна.

Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтад “Төрийн албаны төв байгууллага төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх бөгөөд уг бүртгэлд төрийн албан тушаал эрхэлж байгаа, эрхэлж байсан мэдээлэл болон энэ хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан удирдах албан тушаалтны нөөцийн бүртгэлийг тусгасан байна” гэж заажээ.

Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх журам”-ын дагуу Төрийн албаны төв байгууллагын гаргасан төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлээр 2023 онд 226496 албан хаагч бүртгэгдсэнээс аймгийн хэмжээнд 5741 төрийн албан хаагч байна.

1.3.5.1. Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн мэдээлэл үнэн зөв байна.

Увс аймгийн салбар зөвлөл нь төрийн байгууллагын хүний нөөцийн систем хариуцсан албан хаагчдыг шаардлагатай мэдээ, мэдээллээр ханган, төрийн байгууллагуудад арга зүйн зөвлөгөө өгч байна.

Аймгийн төсвийн байгууллагууд нь Хүний нөөцийн удирдлагын системд төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллээ тогтмол шинэчлэн бүртгэж байна.

Увс аймгийн төрийн байгууллага, төрийн албан хаагчдын
тоо бүртгэлийн судалгаа

Хүснэгт 11.

№	он	Төрийн байгууллагын тоо	Нийт төрийн албан хаагчийн тоо	Үүнээс			
				Төрийн улс төр	Төрийн захиргаа	Төрийн тусгай	Төрийн үйлчилгээ
1	2019	167	4958	154	691	178	3935
2	2020	172	5173	158	675	59	4281
3	2021	174	5170	181	668	59	4262
4	2022	175	5690	156	705	96	4733
5	2023	171	5741	157	690	71	4823

Эх сурвалж: /Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайлан/

1.3.5.2. Төрийн албаны нөөцөд албан хаагчдыг бүртгэсэн байна.

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.7 дахь заалтад “Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалтыг улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулна”, 33.8 дахь заалтад “Энэ хуулийн 33.7-д заасан шалгалтад тэнцсэн иргэнийг төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэнэ. Төрийн жинхэнэ албаны нөөцөд байх хугацаа гурван жил байна” гэж заасан байна.

Аймгийн салбар зөвлөлөөс төрийн албаны ерөнхий шалгалтын бүртгэлийн зар мэдээллийг орон нутгийн телевизүүд болон аймгийн албан ёсны цахим хуудас, аймаг, сумдын ЗДТГ-ын мэдээллийн самбаруудаар олон нийтэд мэдээлж байна. Мөн аймгийн “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн иргэдэд үйлчлэх зөвлөх нь төрийн албаны шалгалтад бүртгүүлэх иргэдэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн бүртгэлийг сүүлийн 6 жилээр хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 12.

№	Он	Шалгалт зохион байгуулсан тоо	Бүртгүүлсэн	Тэнцсэн	Амжилтын хувь
3	2018	1	83	32	38.5
4	2019	2	289	17	5.9
5	2020	2	467	115	24.6
6	2021	2	788	252	32
7	2022	2	371	106	28.6
8	2023	4	529	125	23.6

Эх сурвалж: /Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайлан/

1.3.5.3. Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлд хяналт хийгдэж байгаа ч төсвийн байгууллагуудын ажилтны хувийн хэргийн бүрдэл хангалтгүй байна.

Төрийн албаны зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хууль болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр харьяа төрийн байгууллага, албан хаагчдыг мэдээ, мэдээллээр хангах, зөвлөн туслах, хяналт тавих, зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан байна. Мөн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төрийн албаны стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор сумдын Засаг даргын тамгын газар, ИТХ-ын ажлын албаны хүний нөөцийн удирдлагын бодлого, шийдвэрт хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгах талаар зөвлөмж, чиглэл өгч ажилласан байна.

Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг шинэчлэн баталсан байна. Журмын 2-д “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг нь дараах баримт бичгээс бүрдэнэ” гэж заасан байна.

Аудитын түүвэрт хамрагдсан дараах байгууллагуудын хувийн хэргийн бүрдэл дутуу байна. Үүнд:

- ✓ Эрүүл мэндийн газрын ажилтнуудын хувийн хэргийн бүрдүүлэлт дутуу,
- ✓ Завхан сумын ИТХ-ын 3 ажилтанд хувийн хэрэг байхгүй,
- ✓ Завхан сумын ЭМТ-ийн ажилтнуудын хувийн хэргийн бүрдэл дутуу,
- ✓ Улаангом сумын Ерөнхий боловсролын цогцолбор 2-р сургуулийн ажилтнуудын хувийн хэргийн бүрдэл дутуу,
- ✓ Улаангом сумын ЗДТГ-ын ажилтнуудын хувийн хэргийн бүрдэл дутуу, Боловсрол, соёл, урлаг хариуцсан мэргэжилтний хувийн хэрэг байхгүй,
- ✓ “Чандмань Увс” ХХК-ийн ажилтнуудын хувийн хэргийн бүрдэл дутуу,
- ✓ Увс аймгийн ЗДТГ-ын төрийн үйлчилгээний ажилтнуудын хувийн хэргийн бүрдэл дутуу,

- ✓ Өлгий сумын ЭМТ-ийн ажилтнуудын хувийн хэргийн бүрдэл дутуу,
- ✓ Өмнөговь сумын ЭМТ-ийн ажилтнуудын хувийн хэргийн бүрдэл дутуу,
- ✓ Наранбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн ажилтнуудын хувийн хэргийн бүрдэл дутуу,
- ✓ Наранбулаг сумын Соёлын төвийн ажилтнуудын хувийн хэргийн бүрдэл дутуу, 2 ажилтны хувийн хэрэг байхгүй,
- ✓ Сагил сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн даргын хувийн хэргийн бүрдэл дутуу, мэргэжилтний хувийн хэрэг байхгүй байна.

Цаашид төсвийн байгууллагуудын хувийн хэргийн бүрдлийг хэрхэн хангах талаар тодорхой ажил зохион байгуулж, зөвлөмж чиглэл өгч ажиллахыг зөвлөмж болгов.

БҮЛЭГ 2

Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож байна.

2.1. Иргэндээ үйлчилдэг мэргэшсэн, чадварлаг ил тод төрийн алба бүрдэж байгаа боловч төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай хүний нөөц дутагдалтай байна.

2.1.1. Төрийн албан хаагчдыг орон зайнаас үл хамааруулан сургаж байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/01 дүгээр тогтоолоор баталсан “Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.4-д “Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ”, 5.4.2-д “Улс төрийн намд үйлчилдэггүй, хараат бус төрийн албыг бий болгож, төрийн албан хаагч тогтвортой ажиллах, төрийн албаны шатлах дэвшүүлэх тогтолцоог хэрэгжүүлнэ”, 5.4.4-д “Төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих таатай орчныг бүрдүүлнэ” гэж тусгажээ.

Мөн Аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/02 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2-д “Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, чиг үүргийн уялдааг хангах замаар үйлчилгээний үр дүн, нөлөөг дээшлүүлнэ”, 4.2.3-д “Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулах, төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих таатай орчныг бүрдүүлэх” гэж заажээ.

Төрийн албан хаагчдыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академийн сургалтын төлөвлөгөө, салбар яамдын сургалтын төлөвлөгөө, байгууллагын сургалтын төлөвлөгөөний дагуу болон цаг үеийн шинжтэй сургалтад танхимын болон цахим хэлбэрээр хамруулж байгаа ч аудитын түүвэрт хамрагдсан ихэнх байгууллагуудад сургалт зохион байгуулах төсөв санхүүжилт хүрэлцээгүй байна.

2.1.1.1. Төрийн албаны сургалтын хөтөлбөр нь ил тод, нээлттэй байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академийн сургалтын төлөвлөгөөний хүрээнд Увс аймагт ирсэн квотын дагуу Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалтад төрийн албан хаагчдыг хамруулж байна.

Мөн Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэгт “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу салбар яамдаас сургалт зохион байгуулах дүрэм, журмыг баталж, аудитын түүвэрт хамрагдсан байгууллагууд төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг ахиулах сургалтын дэд төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байна.

2.1.1.2. Төрийн албан хаагчийн сургалтад шаардлагатай санхүүжилт хүрэлцээгүй байна.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагууд төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг ахиулах сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж баталсан боловч ихэнх байгууллагуудад сургалт зохион байгуулах төсөв санхүүжилт хангалтгүй байна. Тухайлбал: Төсөвт байгууллагуудад сургалт зохион байгуулах арга хэмжээний зардал байхгүй, Боловсрол, Эрүүл мэнд, Соёлын салбарт албан томилолтын зардал хүрэлцээгүй байна.

2.1.1.3. Суралцах шаардлагатай төрийн албан хаагчийг сургалтад хамруулж байна.

Засгийн газрын хэрэгжүүлэг агентлаг Удирдлагын академийн зохион байгуулдаг Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалтад 2021 онд 53, 2022 онд 55, 2023 онд 66, 2024 оны хагас жилийн байдлаар 33, нийт 207 албан хаагчийг сургасан байна.

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын сургалтыг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын ажлын алба, Удирдлагын академитай хамтран 2023 оны 03 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд зохион байгуулж танхимаар 200 албан хаагч, цахимаар 850 албан хаагчийг хамруулжээ.

Мөн Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн пүрэв гаригт зохион байгуулдаг “7:4:10” арга зүйн 90 удаагийн сургалтад 19 сумын төсөвт байгууллагуудын давхардсан тоогоор 27500 албан хаагч хамрагдсан байна.

Боловсролын салбарын байгууллагуудын хувьд 2022 оноос багшийн хөгжлийн зардал батлагддаг болсонтой холбоотойгоор сургууль, цэцэрлэгийн багш нарыг зорилтод болон сонголтод модуль сургалтуудад тогтмол хамруулж байна. Мөн салбарын түвшинд жилийн сургалтын төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулсан байна. Түүнчлэн 7 хоног бүр салбарын бүх байгууллагад Боловсролын газрын мэргэжилтнүүд цахимаар сургалт, мэдээлэл хийж байна.

Эрүүл мэнд, Соёлын салбар салбарын түвшинд жилийн сургалтын төлөвлөгөө гарган, бусад аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудын хувьд байгууллагын сургалтын жилийн төлөвлөгөөний дагуу сургалтуудыг зохион байгуулж байна.

2.1.2. Газар зүйн байршлаас үл хамааран мэдлэг чадвартай албан хаагчийг сэлгэн, шилжүүлэн ажиллуулж байна.

Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлд “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэн, сэлгэн ажиллуулах”, 44.1 дэх хэсэгт “Албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцож, эсхүл тухайн байгууллагад 10 ба түүнээс дээш жил нэг албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийг удирдлагын санаачилгаар төрийн албаны нэг байгууллагаас нөгөө байгууллагад тэдгээрийн удирдлагын хооронд харилцан тохиролцсоны дагуу шилжүүлэн ажиллуулж болно” гэж заасан байна.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн дагуу 2013 онд аймгийн төсөвт байгууллагууд болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн нягтлан бодогч нарыг хооронд нь сэлгэн ажиллуулжээ.

Улаангом сумын Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Б/24 дүгээр “Цэцэрлэгийн эрхлэгч нарыг шилжүүлэн ажиллуулах тухай” захирамжаар аймгийн төвийн 11 цэцэрлэгийн эрхлэгч нарыг шилжүүлэн ажиллуулж байгаад 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/49 дүгээр “Цэцэрлэгийн эрхлэгч нарыг шилжүүлэн ажиллах хугацааг дуусгавар болгох тухай” захирамжаар буцаан шилжүүлсэн байна. Мөн Улаангом сумын Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/390 дүгээр захирамжаар Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 сургуулийн захирлыг шилжүүлэн ажиллуулсан байна.

Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын 2024 онд баталсан “Ментор, мэнти багш үйл ажиллагааг зохион байгуулах ажлын удирдамж”-ийн хүрээнд боловсролын салбарын багш нарын хувьд 14 хоногийн хугацаатайгаар тухайлсан

мэргэжлээр сэлгэн туршлага солилцуулан ажиллуулсан байна.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагаас дараах байгууллагуудад газар зүйн байршлаас үл хамааран сэлгэн шилжүүлэн ажиллуулсан байна. Үүнд:

- Аймгийн ЗДТГ: Хууль, эрх зүйн хэлтсийн Эрх зүйн сургалт, сурталчилгаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн Г.Шинэбаярыг 2021 онд Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар, Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн хүний нөөцийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн П.Нямгэрэлийг 2021 онд Нийгмийн даатгалын хэлтэст бичиг хэрэг, хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтнээр, аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Энхбаярыг 2023 онд Санхүү, төрийн сангийн хэлтэст нягтлан бодох бүртгэлийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтнээр,
- Аймгийн ИТХ: Сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажил хариуцсан мэргэжилтнийг 2023 онд аймгийн Прокурорын газарт, Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Г.Сувдааг 2021 онд аймгийн ИТХ-ын аудитын албаны нутгийн өөрөө удирдах байгууллагын хамтын ажиллагаа, шагнал урамшуулал хариуцсан ахлах мэргэжилтнээр, Увс аймаг дахь Шүүхийн тамгын газраас шүүгчийн туслах Н.Эрдэнэ-Очирыг 2024 онд төлөөлөгчийн үйл ажиллагаа, орон нутгийн өмч хариуцсан ахлах мэргэжилтнээр,
- Боловсролын газар: СӨБ хариуцсан мэргэжилтэн Э.Алтанцэцэгийг 2022 онд Боловсролын ерөнхий газарт СӨБ-ийн мэргэжилтнээр, Шинжлэх ухаан инвази хариуцсан мэргэжилтэн Б.Өлзийтэгшийг 2024 онд аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн боловсрол хариуцсан мэргэжилтнээр,
- Орон нутгийн өмчийн газар: Орон нутгийн өмчийн газрын өмч хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Тунгалагийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт мэргэжилтнээр,
- Түргэн сумын Эрүүл мэндийн төв: ЭМТ-ийн лаборант ажилтныг 2024 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн сувилагч, лаборантаар,
- Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар: Наранбулаг сумын Санхүүгийн албаны дарга С.Оюунбилэгийг 2023 онд төсөв, хөрөнгө, оруулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр,
- Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба: аймгийн Шүүхийн тамгын газраас Г.Алтанлхамыг 2022 онд дотоод аудитораар,
- Эрүүл мэндийн газар: Эх барих эмэгтэйчүүд хариуцсан мэргэжилтэн Батжаргалыг 2024 онд Нэгдсэн эмнэлэгт, Нэгдсэн эмнэлгийн эм эмнэлгийн хэрэгсэл хариуцсан мэргэжилтэн Г.Дэлгэрцэцэг 2020 онд эмийн чанар, аюулгүй байдал, эмийн зохистой хэрэглээ, эм эмнэлгийн хэрэгслийн хангамж хариуцсан мэргэжилтнээр,
- Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар: Мэргэжилтэн З.Ариунтуяаг Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын мэргэжилтнээр, Хөдөлмөрийн улсын байцаагч Р.Халх-Очирыг аймгийн ИТХ-ын мэргэжилтнээр, Бөхмөрөн сумын мэргэжилтэн Б.Саранцацралыг сумын ИТХ-ын ажлын албанд, Давст сумын мэргэжилтэн Ж.Энхтүвшинг Баруун бүсийн ахмадын асрамж үйлчилгээний төвийн нийгмийн ажилтнаар,
- Өлгий сумын ЗДТГ: Сумын ИТХ-ын ажлын албаны мэргэжилтнийг ЗДТГ-ын хоршоо, хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтнээр,
- Завхан сумын ЗДТГ-ын хууль, эрх зүй, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн И.Соёлыг Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгчээр тус тус сэлгэн шилжүүлж ажиллуулсан байна.

2.1.3. Төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай хүний нөөц дутагдалтай, бэлтгэх ажил хангалтгүй байна.

Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, хууль тогтоомжтой уялдуулан Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт мэдээллийн технологийн чиглэлээр дараах зорилт, арга хэмжээ тусгажээ.

Хүснэгт 13.

Д/д	Дунд хугацааны бодлогын баримт бичгийн нэр	Зорилго	Зорилт	Хүрэх үр дүн
1	Аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/01 дүгээр тогтоолоор баталсан “Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”	Зорилго 5: Цахим технологид суурилсан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг бүх хүрээнд өргөжүүлэн, хүний эрхийг хангасан шударга ёсны тогтолцоо төлөвшүүлэх, авлигагүй аймаг болно.	5.3-д Мэдээллийг аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогыг хэрэгжүүлнэ.	5.3.1-д Төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоо, үйлчилгээний үр дүнг сайжруулна. 5.3.2-д Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, тайлагналтын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем нэвтрүүлнэ. 5.3.3-д Цахим засаглалыг хөгжүүлж, өндөр хурдны интернэтийн орчныг сайжруулж, хэрэглээг нэмэгдүүлнэ.
2	Аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/02 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”	Зорилго 4: Засаглалын бодлого 4.1-д Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, цахим бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэн, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.	4.1.2-д Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн “Ухаалаг Увс” арга хэмжээг хэрэгжүүлэх	“Нэг иргэн-нэг бүртгэл” үйлчилгээг хэрэгжүүлж, цахим үйлчилгээний стандартыг хангуулна.

Эх сурвалж: /Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичиг/

Дээрх дунд хугацааны бодлогын баримт бичиг, хөтөлбөрт мэдээллийн технологийн чиг үүргийг хариуцан гүйцэтгэх хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх талаар тухайлсан зорилт, арга хэмжээг тусгаагүй байна.

Төрийн албаны зөвлөлийн даргын 2024 оны 136 дугаар тушаалаар “Төрийн байгууллагын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүн” сэдвээр яам, агентлаг, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад хүний нөөцийн аудит хийх багийг байгуулсан байна.

Уг ажлын хүрээнд Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжлийн бодлого, арга хэмжээний явц үр дүнг тооцож, дүгнэлт өгөх, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, шийдвэр гаргуулах зорилгоор Увс аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлөөс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын эрхлэх хүрээний асуудал хариуцсан 20 агентлаг, аймгийн төвийн сум болох Улаангом сумын Засаг даргын тамгын газар зэрэг байгууллагад ажилласан байна.

Аудитад хамрагдсан 20 байгууллагаас мэдээлэл технологийн чиг үүрэг хэрэгжүүлэх орон тоо батлагдсан 11 байгууллага байна. Үүнд:

Хүснэгт 14.

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан орон тоо
1	Аймгийн ИТХ	1
2	Аймгийн ЗДТГ	1
3	Байгаль орчны газар	1
4	Боловсролын газар	1
5	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	1
6	Нийгмийн даатгалын газар	1
7	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	1
8	Хүнс, хөдөө аж ахуйн газар	1
9	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	1
10	Эрүүл мэндийн газар	1
11	Улаангом сумын Засаг даргын тамгын газар	1
12	Биеийн тамир, спортын газар	0
13	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	0
14	Мал эмнэлгийн газар	0
15	Орон нутгийн өмчийн газар	0
16	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	0
17	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	0
18	Статистикийн хэлтэс	0
19	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	0
20	Худалдан авах ажиллагааны газар	0
	Нийт	11

Эх сурвалж: / Увс аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөл /

Сумдын Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв зэрэг байгууллагуудад мэдээлэл технологийн чиг үүрэг хэрэгжүүлэх орон тоо байхгүй байна.

Харин аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт Иргэдийн мэдээллийн технологийн мэдлэг, цахим боловсрол хэрэглээний түвшнийг нэмэгдүүлэх “Өрх бүрд-Цахим иргэн” зорилтот арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн байна.

2.1.4. Төрийн албанд жендерийн тэнцвэртэй байдлыг хангаж байна.

2.1.4.1. Төрийн албан дахь жендерийн эрх тэгш байдлын баталгаа хангагдсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 4/02 дугаар тогтоолоор баталсан “Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.5-д “Бүх нийтэд хүний эрх, жендерийн боловсрол олгох ажлыг зохион байгуулж, жендерийн тэгш байдлыг хангах бодлого баримтлах”, 4.2.6-д “Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлж, улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын бүх хүрээнд эмэгтэйчүүд үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор хангах” гэж тусгасан байна.

Аймгийн жендерийн хорооны салбар хороодыг сумдад 2018-2024 оны хооронд байгуулжээ.

Аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар нутгийн захиргааны байгууллагын улс төрийн удирдах албан тушаалд 133 хүн ажиллаж байгаагаас эмэгтэй 16 буюу 12.0 хувь, эрэгтэй 117 буюу 88.0 хувийг тус тус эзэлж байна.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Төрөөс эрэгтэй, эмэгтэй хүний төрийн албанд орох, албан тушаал эрхлэх тэгш эрх бодитой хэрэгжих боломж, нөхцөлөөр хангахын тулд дараах бодлого хэрэгжүүлнэ”, 10.1.1 дэх заалтад “Томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15 хувиас, дүүрэгт

20 хувиас, суманд 25 хувиас, хороонд 30 хувиас доошгүй байх” гэсэн заалтын хэрэгжилт Өмнөговь, Улаангом сумаас бусад сумдад хангагдаагүй байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар нутгийн захиргааны байгууллагын төрийн захиргааны удирдах албан тушаалд 44 хүн ажиллаж байгаагаас аймгийн ЗДТГ-ын дарга хэлтэс албадын даргын 57.1 хувь нь эрэгтэй, 42.9 хувь нь эмэгтэй, сумын ЗДТГ-ын дарга, албадын дарга нарын 59.4 хувь нь эрэгтэй, 40.6 хувь нь эмэгтэй байна.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтад “Төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөлаймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх” гэсэн заалтын хэрэгжилт аймгийн дүнгээр хангагдаж байгаа ч Баруунтуруун, Завхан, Тариалан, Тэс, Цагаанхайрхан сумдад хангагдаагүй байна.

Аймгийн дүнгээр аймаг, сумын ЗДТГ-ын дэргэд ажиллаж байгаа 224 салбар хороо комисс, зөвлөлийн 203 нь буюу 90.6 хувь нь эрэгтэй удирдлагатай, бүрэлдэхүүнд нь 2131 төрийн албан хаагч ажиллаж байгаагаас 55.5 хувь нь эрэгтэй, 44.5 хувь нь эмэгтэй байна.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Төрийн байгууллагын дэргэдэх болон үндэсний хэмжээний хороо, зөвлөл, комисс (цаашид "хороо" гэх) зэрэг зөвлөлдөх буюу хамтын удирдлагын байгууллагад аль нэгэн хүйсийн төлөөлөл нийт гишүүний 40 хувиас доошгүй байна” гэсэн заалтын хэрэгжилт аймгийн дүнгээр хангагдаж байна.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хороо, хүний эрхийн үндэсний комиссын хамтарсан 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/107, А/02/202, 02/009 дүгээр “Үлгэрчилсэн заавар батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралтаар “Төрийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг шийдвэрлэх хэм хэмжээг тусгуулах, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн үлгэрчилсэн заавар”-ыг баталсныг төрийн байгууллагууд мөрдөж байна.

2.1.4.2. Төрийн албанд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах эрх зүйн орчин бүрдсэн ч хэрэгжилт хангалтгүй байна.

2016 онд баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн зорилтыг “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хамгаалах талаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, оролцоо, баримтлах зарчмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлжээ.

Хуулийн 5 дугаар бүлгийн 17 дугаар зүйлд “Хөдөлмөрлөх эрх”, 17.1 дэх хэсэгт “Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орох, албан тушаал дэвших, цалин хөлс, нөхөн олговор авах, хөдөлмөр эрхлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд бусадтай адил тэгш хамрагдах эрхтэй”, 17.3 дахь хэсэгт “Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бие эрхтэн, хөгжлийн онцлогт нийцсэн ажлын байрыг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу бий болгож ажиллуулах үүрэгтэй”, 18 дугаар зүйлд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг төрөөс дэмжих”, 18.1 дэх хэсэгт “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтэд төрөөс дараах дэмжлэг үзүүлнэ”, 19 дүгээр зүйлд “Ажлын байрны сонгон шалгаруулалт”-ыг тус тус зохицуулсан байна.

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол доор дурдсан төрийн захиргааны албан тушаалд энэ хуулийн 22.1-д заасан нийтлэг шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг хангасан иргэнийг томилно” гэж заажээ. Үүнд: 23.2.1-д тэргүүн түшмэл, 23.2.2-д эрхэлсэн түшмэл, 23.2.3-д ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд

томилогдоход тавигдах шаардлагад хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд хөнгөлөлттэй нөхцөлөөр тусгаж өгсөн байна.

Төсөвт байгууллагуудын ажлын байрны хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүний бие эрхтэн, хөгжлийн онцлогт нийцсэн ажлын байрыг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу бий болгох асуудал учир дутагдалтай байна. Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудын хувьд зарим байгууллагын гадна тусгай шатнаас өөр шийдвэрлэсэн асуудал байхгүй байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хувьд дотор тусгай 00, капитал зам хийсэн байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дахь хэсэгт “Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна” гэж заасан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сумдаар нь сүүлийн 4 жилээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 15.

Д/д	Сум	2020			2021			2022			2023		
		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
1	Баруунтуруун	122	59	63	113	55	58	109	36	52	84	52	32
2	Бөхмөрөн	121	72	49	129	75	54	90	17	35	92	59	33
3	Давст	103	57	46	123	70	53	109	36	48	86	55	31
4	Завхан	103	54	49	111	56	55	81	8	39	71	41	30
5	Зүүнговь	138	88	50	165	96	69	151	78	61	127	70	57
6	Зүүнхангай	107	66	41	105	64	41	97	24	35	78	54	24
7	Малчин	120	73	47	119	73	46	105	32	43	93	58	35
8	Наранбулаг	277	160	117	203	121	82	194	121	73	170	99	71
9	Өлгий	180	97	83	174	97	77	164	91	72	115	72	43
10	Өмнөговь	192	99	93	153	85	68	124	51	55	132	72	60
11	Өндөрхангай	154	81	73	155	87	68	140	67	59	121	68	53
12	Сагил	145	88	57	141	88	53	141	68	48	91	61	30
13	Тариалан	211	116	95	184	100	84	189	116	82	136	89	47
14	Түргэн	101	60	41	121	73	48	116	43	46	97	37	60
15	Тэс	198	122	76	227	145	82	216	143	77	173	136	37
16	Ховд	120	67	53	126	66	60	121	48	59	101	52	49
17	Хяргас	94	52	42	98	53	45	103	30	45	76	44	32
18	Цагаанхайрхан	150	63	87	146	63	83	122	49	60	90	52	38
19	Улаангом	1834	983	851	2122	1168	954	2211	2138	979	1461	851	610
	Бүгд	4470	2457	2013	4715	2635	2080	4583	3196	1968	3394	2022	1372

Эх сурвалж: / Увс аймгийн Нийгмийн даатгалын газар/

Судалгаанаас харахад 2020 онд 4470, 2021 онд 4715, 2022 онд 4583, 2023 онд 3394 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудаас 117 байгууллагад нийт 391 хөгжлийн бэрхшээлтэй иргэн 2023 оны жил эцсийн байдлаар ажиллаж байгаа нь нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 11.5 хувийг эзэлж байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.3 дахь хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 144.2-т зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байх бөгөөд уг төлбөрийг сар бүр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлнө” гэж заажээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр төлсөн байдлыг сүүлийн 5 жилээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 16.

№	Он	Аж ахуйн нэгж, байгууллага	Мөнгөн дүн
1	2020	Байхгүй	0
2	2021	Байхгүй	0
3	2022	Хаан банк	16,800,000
4	2023	Хаан банк	20,350,000
		Хотгор шанагийн уурхай	3,850,000
5	2024	Хаан банк	2,640,000

Эх сурвалж: / Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /

Судалгаанаас харахад 2021 оноос өмнө мөнгөн төлбөр ороогүй байх бөгөөд сүүлийн 3 жилд 2 аж ахуйн нэгжээс мөнгөн төлбөр орсон байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.5 дахь хэсэгт "Энэ хуулийн 144.3-т заасан төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журмыг Засгийн газар батална. Энэ төлбөрийг гагцхүү хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зарцуулах бөгөөд төлбөр хураалт, зарцуулалт, үр ашгийн талаар жил бүр олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тайлагнана" гэж заасан байна. Гэтэл дээрх 2022-2024 онд төлсөн 43,640.0 мянган төгрөгийг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн хувьд 2023 оны байдлаар 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийт ажилтнуудын 4 хувьд хүрэхгүй байгаа дараах байгууллагууд байна. Үүнд:

Хүснэгт 17.

Д/д	Байгууллагын нэр	Нийт ажилтны тоо	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо	Эзлэх хувь
1	Бөхмөрөн сумын ЕБС	54	2	3.7
2	Улаангом сумын 3-р цэцэрлэг	48	1	2.1
3	Улаангом сумын ЕБ-ын цогцолбор 1-р сургууль	216	7	3.2
4	Улаангом сумын 6-р цэцэрлэг	42	1	2.4
5	ГХБХБГ	47	0	0
6	Улаангом сумын 4-р цэцэрлэг	46	1	2.2
7	Увс аймгийн Прокурорын газар	27	1	3.7
8	Улаангом тохижилт үйлчилгээ	45	0	0
9	Ойрад хөгжимт жүжгийн театр	74	2	2.7
10	Хяргас сумын ЗДТГ	31	1	3.2
11	Хяргас сумын ЭМТ	33	0	0
12	Зүүнговь сумын ЭМТ	33	1	3
13	Тэс сумын Хүүдийн цэцэрлэг	34	1	2.9
14	Завхан сумын ЗДТГ	29	0	0
15	Завхан сумын ЕБС	49	0	0
16	Завхан сумын ЭМТ	33	1	3
17	Цагаанхайрхан сумын ЗДТГ	27	0	0
18	Малчин сумын ЭМТ	32	0	0
19	Малчин сумын ЗДТГ	27	0	0
20	Сагил сумын ЕБС	40	1	2.5
21	Тэс сумын ЗДТГ	37	0	0
22	Зүүнхангай сумын ЭМТ	35	0	0
23	Зүүнхангай сумын ЗДТГ	29	0	0
24	Өндөрхангай сумын ЗДТГ	31	1	3.2
25	Өндөрхангай сумын ЭМТ	37	0	0
26	Наранбулаг сумын ЭМТ	28	0	0
27	Наранбулаг сумын ЗДТГ	28	1	3.6

28	Наранбулаг сумын Хүүхдийн цэцэрлэг	32	1	3.1
29	Тариалан сумын ЭМТ	31	1	3.2
30	Тариалан сумын Хүүхдийн цэцэрлэг	37	1	2.7
31	Тариалан сумын ЗДТГ	34	1	2.9
32	Увс аймгийн ЗДТГ	101	1	0.1
33	Түргэн сумын ЭМТ	27	1	3.7
34	Түргэн сумын ЕБС	46	0	0
35	Ховд сумын ЭМТ	26	1	3.8
36	Давст сумын ЕБС	36	1	2.8
37	Өлгий сумын ЭМТ	32	0	0
38	Улаангом сумын 8-р цэцэрлэг	41	1	2.4
39	Улаангом сумын ЕБ-ын 3-р сургууль	106	3	2.8
40	Улаангом сумын 10-р цэцэрлэг	35	1	2.8
41	Улаангом сумын 12-р цэцэрлэг	38	1	2.6
42	Улаангом сумын 11-р цэцэрлэг	37	0	0
43	Ундарга Увс	192	4	2.1
44	Увс хүнс	73	2	2.7
45	Хас банкны Увс салбар	30	1	3.3
46	Ундарга Констракшин	27	0	0
47	Сонос Увс	26	0	0
48	Эрдмийн эхлэл	43	1	2.3
49	Сод Тосон Дэлгэрэх	36	0	0
50	Номин агуулах худалдааны Улаангом салбар	71	2	2.8

Эх сурвалж: / Увс аймгийн Нийгмийн даатгалын газар /

Дээрх судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудад Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2, 144.3 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж чиглэл өгч хэрэгжилтийг хангуулахыг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт зөвлөмж болгов.

2.2. Иргэд төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран авах нөхцөл боломж бүрдсэн байна.

2.2.1. Цахим технологи ашиглан иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх тогтолцоог боловсронгуй болгож, шат дамжлагыг цөөлөн, хүнд суртлыг арилгасан байна.

Дижитал аймаг төслийг 2023 оноос хэгжүүлэн аймагт Төрийн цахим үйлчилгээний хэлтэс байгуулагдан ажиллаж байна. “Дижитал аймаг Увс” арга хэмжээний хүрээнд төр, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих нийт 12 төрлийн системийн шийдлийг нэвтрүүлж, 20 гаруй үйлчилгээг нэгтгэсэн “Иргэний аппликейшн”-ийг хөгжүүлэн хэрэглээнд нэвтрүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбоотой дэд бүтэц, авто зам, инженерийн шугам сүлжээ, барилга байгууламж, газрын дээр болон доор байрлах байгууламжууд, орон нутгийн бэлчээрийн даац, тариалангийн талбай, байгалийн үзэсгэлэнт түүх дурсгалт газар, аялал жуулчлалын цогцолбор, үйлчилгээний байгууллагуудын төвлөрлийг нэгдсэн байдлаар харуулах “Газар зүйн нэгдсэн систем”,
- Боловсролын байгууллагын удирдлагууд, багш, эцэг эх, сурагчдад зориулсан “Боловсролын систем”,
- Шуурхай удирдлага, яаралтай тусламж болох цагдаа, түргэн, онцгой байдлын дуудлага хүлээн авах, хуваарилах, дуудлагын хаяг руу замчлах буюу яаралтай тусламжийн үйлчилгээг түргэн шуурхай иргэдэд хүргэх, хувийн аж ахуйн нэгжүүд хүргэлтийн автомашинаа хянах боломжтой “Шуурхай удирдлага, хяналтын систем”,
- Орон нутгийн замын зорчих хөдөлгөөний хяналт, аюулгүй байдал, зам ашиглалт, ачаалал зэрэг зорчих хөдөлгөөнтэй холбоотой асуудлуудыг шийдэх, төлбөр хураамж, жуулчдын тоон мэдээллийг бодитоор бүртгэх, тооцоолох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Ухаалаг хаалганы систем”,

- Төр хувийн хэвшил, бизнес эрхлэгчид үйл ажиллагаандаа шаардлагатай шийдвэр гаргалтад туслах бодит цагийн горимоор ажиллах тоон статистик үзүүлэлтийг агуулсан “Мэдээллийн нэгдсэн дашбоард”,
- Төрийн үйлчилгээ авах, өргөдөл, гомдол, санал, хүсэлтээ илгээх, бараа бүтээгдэхүүнээ олон нийтэд сурталчлах, эмнэлгийн цаг авах, шинжилгээний хариу авах, аюул зөрчлийг мэдэгдэх, хэрэглээний төлбөрөө төлөх, хүүхдийнхээ боловсролын мэдээлэл авах, хот хоорондын автобус хаана явж байгааг харах, ажлын байр, зар, цаг үеийн мэдээ мэдээлэл авах.

2.2.2. Орон нутагт төрийн үйлчилгээ жигд, хүртээмжтэй хүрч байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагуудаар дамжуулан төрийн үйлчилгээ жигд хүртээмжтэй хүрч байна.

Мөн Төрийн үйлчилгээг цахимжуулах, Монгол Улсыг цахим үндэстэн болох эхлэлийг тавьж байгаа E-mongolia системд 50 байгууллагын 182 үйлчилгээ, орон нутгийн 12 байгууллагын 51 үйлчилгээг цахимжуулж, холбох ажлыг ЦХХХЯ, e-Mongolia академитай хамтран зохион байгуулсан байна. Өнөөдрийн байдлаар e-Mongolia системээс иргэн хуулийн этгээд цахимаар авах 1188 үйлчилгээ бүртгэлтэй байгаагаас Увс аймгийн 19 сумын операторын системээр 823 төрлийн үйлчилгээг 9914 иргэнд үзүүлсэн байна.

Засгийн газрын хэрэг эрхлэх газраас төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар Төрийн бус байгууллагаар үнэлгээ хийлэгдэг боловч орон нутагт үнэлгээний талаарх тайлан мэдээ байхгүй байна.

Аудитын явцад 300 гаруй иргэдээс санал асуулга авахад дараах байдлаар хариулсан байна. Үүнд:

- Орон нутагт төрийн үйлчилгээ жигд хүртээмжтэй хүрч байна уу? гэсэн асуултад тийм гэж 258, үгүй гэж 40 иргэн хариулсан байна.

Дээрх санал асуулгын дүнгээс харахад орон нутагт төрийн үйлчилгээ жигд, хүртээмжтэй байна гэж дүгнэхээр байна.

2.3. Төрийн үйлчилгээний ил тод, нээлтэй байдалд хийсэн санал асуулгын дүнгээс үзэхэд иргэд сэтгэл ханамжтай байна.

Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас 2022 онд үйлчилгээний чанар, хүртээмж дэх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг тодорхойлж, үнэлэлт өгөх, цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах зорилгоор иргэдээс санал асуулга авч хэрэглэгчийн үнэлгээний тайлан гаргасан байна. Санал асуулгаар байгууллагын үйлчилгээний талаар авсан үнэлгээнд сайн гэж 67 хувь нь, мэргэжилтний харилцаа, ёс зүйн талаар авсан үнэлгээнд сайн гэж 62 хувь нь хариулсан байна.

Харин Аудитын түүвэрт хамрагдсан бусад байгууллагын хувьд сэтгэл ханамжийн судалгаа хийж байгаагүй байна.

Аудитын явцад 300 гаруй иргэдээс санал асуулга авахад дараах байдлаар хариулсан байна. Үүнд:

- Орон нутагт төрийн үйлчилгээ жигд хүртээмжтэй хүрч байна уу? гэсэн асуултад тийм гэж 258, үгүй гэж 40 иргэн хариулсан байна.
- Төрийн байгууллагын үйлчилгээ иргэдэд ил тод хүрч байна уу? гэсэн асуултад тийм гэж 264 иргэн, үгүй гэж 36 иргэн хариулсан байна.
- Төрийн үйлчилгээг цахимаар авч чадаж байна уу? гэсэн асуултад тийм гэж 264, үгүй гэж 32 иргэн хариулсан байна.
- Төрийн үйлчилгээг авахад танд хүндрэл гарч байна уу? гэсэн асуултад тийм гэж 146 иргэн, үгүй гэж 151 иргэн хариулсан байна.
- Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа уялдаа холбоотой ажиллаж байна уу? гэсэн асуултад тийм гэж 253 иргэн, үгүй гэж 43 иргэн хариулсан байна.

Төрийн үйлчилгээний ил тод, нээлтэй байдалд хийсэн санал асуулгын дүнгээс үзэхэд иргэд сэтгэл ханамжтай байна.

2.3.1. Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа уялдаа холбоотой ажиллаж байна.

Аймгийн бүх шатны төрийн байгууллагууд ERP, ABLE системийг үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж уялдаа холбоотой ажиллаж байна.

Боловсролын салбарын бүх шатны байгууллагууд ESIS систем ашиглан салбарын бүхий л мэдээ мэдээллийг солилцон ажиллаж байна.

2.3.2. Төрийн үйлчилгээний ил тод нээлттэй байдалд холбогдох байгууллагууд судалгаа хийж, хяналтын үр нөлөөтэй тогтолцоо бүрдсэн байна.

Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан байна. Мөн тогтоолын хавсралтад Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор орсон нэмэлт өөрчлөлтийг 2022 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Тухайн тогтоолд нийцүүлэн орон нутагт хэрэгжүүлэх "Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал"-ыг аймгийн Засаг даргын 2017 оны А/281, 2021 оны А/166 дугаар тушаалаар тус тус батлан мөрдөж байсныг Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/06 дугаар захирамжаар шинэчлэн баталсан байна. Уг аргачлалын 5, 6 дугаар хавсралтад агентлагийн болон сумдын ажлыг үнэлж дүгнэх үзүүлэлтийг тусгасан байна.

Аргачлалын хавсралтаар баталсан үзүүлэлтийн дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс жил бүр 3 ангиллын 19-20 үзүүлэлтээр үнэлгээ хийж байна. Үнэлгээний маягтын 3-д "Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ" гэж тусгасны дагуу 2020 он хүртэл шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, байгууллагын ил тод байдлын үнэлгээ, шударга байдлын түвшний үнэлгээ гэсэн үзүүлэлтээр, 2021 оноос шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үнэлгээ, шинэлэг болон бусдад түгээх сайн туршлага /онцлох ажил/-ын үнэлгээ гэсэн үзүүлэлтээр төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдалд хяналт хэрэгжүүлж байна.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтын хүрээнд төсөвт байгууллагуудын www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байдалд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас жил бүр хяналт хийж байна. Сүүлийн 10 жилийн тоо мэдээг судалгаагаар харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 18.

Д/д	Он	Байршуулах мэдээллийн тоо	Байгууллагын тоо	Байршуулбал зохих мэдээлэл	Байршуулсан мэдээллийн тоо	Огт байршуулаагүй	Мэдээлэлтийн хувь
1	2015	23	260	23920	22580	1340	94.4
2	2016	23	2661	244812	244322	490	99.8
3	2017	23	247	22724	21633	1091	95.2
4	2018	28	172	19264	18975	289	98.5

5	2019	28	185	20720	20098	622	97
6	2020	28	173	19376	19213	163	99.2
7	2021	29	142	16472	16436	36	99.8
8	2022	29	144	16704	16270	434	97.4
9	2023	29	147	17052	15858	1194	93
10	2024	29	149	17284	16714	570	96.7

Эх сурвалж: / Санхүүгийн хяналт дотоод аудитын алба/

Судалгаанаас харахад 2015-2024 оны хооронд төсөвт байгууллагуудын www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг 93-99.2 хувьтай оруулсан байна.

2.3.3. Орон нутагт төрийн албаны авлигын индексийг тогтоохгүй байна.

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Авлигатай тэмцэх газар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 18.1.3 дахь заалтад “Авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх”, 18.1.7 дахь заалтад “Төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” гэж заасан байна.

Авлигын индексийг тооцож мэдээлэх нь авлигын эсрэг үйл ажиллагааны бодлого, хөтөлбөрийг боловсруулахад ашиглах, хэрэгжилтийг үнэлж дүгнэх, олон нийтийг авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангахад чиглэгддэг байна.

Авлигатай тэмцэх газраас аймаг бүрд шударга байдлын түвшний үнэлгээг хийх Төрийн бус байгууллагыг тусгайлан шалгаруулж, шалгарсан Төрийн бус байгууллагаас аймгийн шударга байдлын үнэлгээг зохион байгуулан дүнг Авлигатай тэмцэх газарт хүргүүлдэг байна.

Шударга байдлын түвшний үнэлгээг 2 жилд нэг удаа хийх хуулийн зохицуулалттай боловч зарим тохиолдолд жил бүр хийсэн байна.

Увс аймаг шударга байдлын түвшний үнэлгээгээр 2015 онд 79.4, 2016 онд 71.9, 2018 онд 74, 2019 онд 72.4, 2021 онд 77.8, 2022 онд 74 оноотой үнэлэгдсэн байна.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Орон нутагт хэрэгжүүлэх хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөрийг боловсруулаагүй байгаа нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.
2. Зарим хууль тогтоомжийн тодорхойгүй зүйл заалт, харилцан уялдаа муутай байдлаас шалтгаалж төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж хууль бусаар томилогдох, чөлөөлөгдөх зөрчил давтагдан гарснаар төрд хохирол учирсан байна.
3. Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 292 дугаар тогтоолыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал хэрэгжүүлээгүй байна.
4. Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудаас 10 байгууллагын 10 албан тушаалд түр орлон гүйцэтгэгч, 8 байгууллагын 8 сул орон тоонд хуульд заасан шаардлагыг хангаагүй албан хаагч ажиллаж байна.
5. Эрүүл мэндийн газар нь хүүхэд асрах чөлөөтэй байсан албан хаагчийг урд эрхэлж байсан ажилд нь эргүүлэн авахаар гарсан тушаалыг хэрэгжүүлээгүй, Засгийн газрын баталсан албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг мөрдөөгүй байна.
6. Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудаас 12 төсвийн байгууллагын албан хаагчдын хувийн хэргийн бүрдэл хангалтгүй байна.
7. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2, 144.3 дахь заалтын хэрэгжилт хангалтгүй байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллах нөхцөл бүрдэхгүй байна.
8. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалын дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсээс төрийн байгууллагуудад хяналт шинжилгээ хийж байна.
9. Төсөвт байгууллагууд орон нутгийн нэмэгдлийг 20-80 хувиар, бусад нэмэгдлийг хууль, тогтоомжийн хүрээнд олгож байна.
10. Төрийн албан хаагчдыг батлагдсан төлөвлөгөөний дагуу танхимын болон цахим хэлбэрээр сургалтад хамруулж байна.

Зөвлөмж

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд:

1. Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 292 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах.

Аймгийн Засаг даргад:

2. Аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж ажиллах.
3. Түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа болон сул орон тоонд хуульд заасан шаардлага хангасан иргэдийг ажиллуулах зөвлөмж, чиглэлийг төрийн байгууллагуудад хүргүүлэх.

Төрийн албаны Увс аймаг дахь салбар зөвлөлд:

4. Хууль бусаар томилогдож, чөлөөлөгдсөн зөрчлийн шийдвэрлэлтийг хангуулах, цаашид хууль тогтоомжийг сурталчлах замаар урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.
5. Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт боловсруулах, хувийн хэргийн бүрдүүлэлтийг хангуулах чиглэлээр төрийн байгууллагуудыг бодлого, арга зүйгээр хангах.

Эрүүл мэндийн газарт:

6. Засгийн газрын баталсан албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг мөрдөж ажиллах, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангах.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт:

7. Аж ахуйн нэгж, байгууллагуудад Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2, 144.3 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж, чиглэл өгч хэрэгжилтийг хангуулах.

ҮАГ-ын нэгтгэл тайланд тусгуулахаар уламжлах санал:

1. Сангийн яамнаас төсөв батлахдаа тухайн байгууллагын батлагдсан бүтэц орон тоотой уялдуулах, Төрийн албаны зөвлөлд ажлын байрны албан тушаалын тодорхойлолтыг хүсэлт хүргүүлэх бүрд шийдвэрлэх.

АУДИТЫН ТАЙЛАНТ

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Т.НАМЖИЛ
Т.АМАРМЭНД
Б.НЯМБУУ

Увс аймаг Улаангом сум, 3-р баг, аймгийн Засаг даргын
тамгын газрын байр, 3 давхарт Утас: 7045-3317
И-мэйл: Uvs@audit.gov.mn. Веб сайт: www.audit.mn